

ҮНДЭСНИЙ ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ХҮРЭЭНД

ГАЗАР, ЗАГАС, ОЙН НӨӨЦИЙН ЭДЭЛБЭРИЙН

ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛЫН
САЙН ДУРЫН ЗӨВЛӨМЖ



ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ



ҮНДЭСНИЙ ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД

ГАЗАР, ЗАГАС, ОЙН НӨӨЦИЙН ЭДЭЛБЭРИЙН¹

ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛЫН САЙН ДУРЫН ЗӨВЛӨМЖ

Энэхүү баримт бичиг нь улс орнууд, олон улсын байгууллагууд, иргэний нийгэм ба хувийн хэвшлийн байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагууд, хөдөө аж ахуйн судалгааны институтууд, хүмүүнлэгийн сангуудын оролцоотойгоор Дэлхийн Хүнсний Аюулгүй Байдлын Хороо (ДХАБХ) –гоор ахлуулсан олон талт оролцогч талуудын тохиролцооны үндсэн дээр бий болсон “Үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалын сайн дурын зөвлөмж” –ийн орчуулга юм. 2012 оны 5-р сард ДХАБ зөвлөмжийг баталсан юм.

НУБ-ЫН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА РОМ ХОТ, 2012 ОН

1 Орчуулагчийн тайлбар: Эдэлбэр гэдэг үгийг Монгол хэлний толь бичигт “хүний ашиглан хэрэглэх өмч, хөрөнгө” хэмээн тайлбарлажээ. Энэхүү зөвлөмжид газар, загас, ойн нөөцийг ашиглах, эзэмших, өмчлөх болон албан, албан бус, зүй ёсны эрх гэх мэт бүх төрлийн ашиглалтын хэлбэртэй холбоотой асуудлуудыг тусгасан учир нийтэд нь Эдэлбэр хэмээн орчуулав.

Эхний хэвлэл: 2012 оны 10-р сар

2 дахь хэвлэл: 2013 оны 4-р сар

Энэхүү материалд ашигласан тайлбар, тодорхойлолт нь аливаа улс орон, газар нутаг, хот суурин газар, тэдгээрийн захиргааны байгууллага, хил хязгаарын хуулийн болон хөгжлийн төлөвийн талаархи НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын (ХХААБ) аливаа үзэл, баримтлалыг агуулаагүй болно. Энэ материалд патент бүхий аливаа компани, үйлдвэрлэгчийг дурьдсан нь ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч бусадтай харьцуулан санал болгож байгаа гэсэн үг биш юм.

ISBN 978-92-5-107277-6 (хэвлэлт)

E-ISBN 978-92-5-107557-9 (PDF)

© ХХААБ 2012

ХХААБ нь энэ материалыг ашиглах, дахин үйлдвэрлэх болон тараахыг зөвшөөрнө. Харин зааснаас бусад тохиолдолд буюу материалыг хувийн судалгаа, сургалт, эсвэл арилжааны бус бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах зорилгоор ашиглах бол ХХААБ-д мэдэгдэж, ХХААБ-с эх хувилбарыг хэвлэн олшруулахыг зөвшөөрсөн бөгөөд ХХААБ-ын хэрэглэгчийн үзэл баримтлалд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй тохиолдолд хувилах, хэвлэх боломжтой.

Хэрэв орчуулах, дахин борлуулах болон бусад арилжааны зорилгоор ашиглах хүсэлтэй байвал www.fao.org/contact-us/license эсхүл copyright@fao.org-т хандаж зөвшөөрөл авах шаардлагатай.

Та ХХААБ-ын мэдээллийн материалуудыг ХХААБ-ын вэб сайтаас (www.fao.org/publications) авахаас гадна publications-sales@fao.org хаягаар худалдаж авах боломжтой.

Агуулга

Оршил

IV

БҮЛЭГ 1

- Эхлэл 7
- 1. Зорилго 7
- 2. Шинж чанар ба хамрах хүрээ 2

БҮЛЭГ 2

- Нийтлэг үндэслэл 3
- 3. Эдэлбэрийн хариуцлагатай засаглалын үндсэн зарчим 3
- 4. Эдэлбэртэй холбоотой эрх, үүргүүд 6
- 5. Эдэлбэртэй холбоотой бодлого, эрх зүйн болон бүтэц-зохион байгуулалтын тогтолцоо 9
- 6. Үйлчилгээ үзүүлэх 11

БҮЛЭГ 3

- Эдэлбэрийн эрх, үүргийн хуваарилалт ба хуулийн зохицуулалт 13
- 7. Баталгаа 13
- 8. Төрийн эзэмшлийн газар, загас, ойн нөөц 15
- 9. Уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэд 17
- 10. Албан бус эдэлбэр 20

БҮЛЭГ 4

- Эдэлбэрийн эрх, үүргийг шилжүүлэх болон бусад өөрчлөлтүүд 21
- 11. Зах зээл 21
- 12. Хөрөнгө оруулалт 23
- 13. Газрын нэгтгэл болон дахин зохион байгуулалтын арга замууд 26
- 14. Эрх сэргээх 28
- 15. Дахин хуваарилалтын шинэчлэлүүд 29

БҮЛЭГ 5

- Эдэлбэрийн удирдлага 33
- 17. Эдэлбэрийн эрхийн бүртгэл 33
- 18. Үнэлгээ 35
- 19. Татвар ногдуулалт 36
- 20. Зохицуулалттай орон зайн төлөвлөлт 37
- 21. Эдэлбэрийн эрхтэй холбоотой маргаан шийдвэрлэлт 38
- 22. Хил дамнасан асуудал 39

БҮЛЭГ 6

- Уур амьсгалын өөрчлөлт болон онцгой байдлын үед авах арга хэмжээ 40
- 23. Уур амьсгалын өөрчлөлт 40
- 24. Байгалийн гамшиг 41
- 25. Газар, загас, ойн эдэлбэртэй холбоотой зөрчилдөөн 42

БҮЛЭГ 7

- 26. Сурталчилгаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ 44

Оршил

Энэхүү сайн дурын зөвлөмж нь бүх нийтийн хүнсний аюулгүй байдлыг хангах болон үндэсний хүнсний аюулгүй байдлын бодлогын хүрээнд зохих хэмжээний хангалттай хүнстэй байх эрхийг системтэйгээр баталгаажуулах явдлыг дэмжих эрхэм зорилгын үүднээс газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн засаглалыг сайжруулахад гарын авлага болгон ашиглах, удирдамжаар хангах зорилготой юм.

Энэхүү зөвлөмж нь тогтвортой хөгжлийн зарчим дээр үндэслэн, мөн газрын асуудал хөгжил дэвшилд голлох үүрэгтэй гэдэг үүднээс газар, загас, ойн нөөцийг эзэмших, тэгш эрхтэйгээр ашиглах, хүртэх явдлыг хөхүүлэн дэмжих замаар өлсгөлөн, ядуурлыг арилгах дэлхий нийтийн болон үндэсний хэмжээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн.

Өлсгөлөн, ядуурлыг арилгах явдал болон байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт нь газар, загас, ойн нөөц нь нийт хүмүүс, нутгийн иргэд болон бусдад хэр хүртээмжтэй байгаагаас ихээхэн хамаарна. Олон хүний, ялангуяа хөдөөгийн ядуу дорой иргэдийн амьжиргаа нь эдгээр байгалийн нөөцөөс хүртэж ашиглах боломжоор тэд хэр найдвартай, тэгш байдлаар хангагдсан бэ гэдгээс шалтгаалдаг. Эдгээр нөөц нь хүмүүст хоол хүнс, орон байрны хангамжийнх нь эх үүсвэр, нийгэм, соёл, шашны зан үйлийнх нь үндэслэл болж, улс орны эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл нь болдог.

Газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн талаар хариуцлагатай зохицуулалт хийх нь байгалийн бусад нөөц түүний дотор ус болон эрдэс баялгийн нөөцийг эзэмшиж ашиглахтай салшгүй холбоотой гэдгийг дурьдах нь зүйтэй. Эдгээр байгалийн нөөцийг захиран зарцуулах янз бүрийн үндэсний хэмжээний аргачлал, систем байдгийг харгалзан, улс үндэстнүүд эл зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ үндэснийхээ онцлогт тохируулан тухайн нөхцөл байдалд байгалийн нөөц баялгаа хэрхэн цогц байдлаар эзэмшиж, захиран зарцуулахаа шийдвэрлэх нь зүйтэй.

Газар, загас, ойн нөөцийг хүмүүс, нутгийн иргэд болон бусад хэрэглэгчдэд хүртээмжтэй болгох асуудлыг байгалийн нөөцийн эдэлбэрийн системүүдээр дамжуулан тодорхойлж зохицуулдаг. Эдгээр эдэлбэрийн системийн дагуу хэн ямар нөөцийг, хэдий хугацаагаар, ямар нөхцөлтэйгээр ашиглаж болохыг тодорхойлдог. Эдэлбэрийн системүүд нь батлагдсан бодлого, хуулиуд болон бичигдээгүй хууль, тухайлбал ёс заншил, бодит амьдрал дээр үндэслэсэн байж болно.

Дэлхийн өсөн нэмэгдэж буй хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах шаардлага болон байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас газар, загас, ойн нөөцийн хүрэлцээ буурч байгаатай холбоотойгоор эдэлбэрийн системд тулгарах хүндрэл бэрхшээлүүд нэмэгдсээр байна. Эдэлбэрийн эрх хангалтгүй, баталгаагүй байгаа нь эмзэг байдал, өлсгөлөн, ядуурлыг нэмэгдүүлж, байгалийн нөөцийн эзэмшлийн төлөөх өрсөлдөөнийг зөрчилдөөн болон хувиргаж, байгаль орчны доройтол хүргэх нөхцлийг бүрдүүлж байна.

Эдэлбэрийн засаглал нь хүмүүс, нутгийн иргэд болон бусад хэрэглэгчдэд газар, загас, ойн нөөцийг ашиглах, хянах эрх, үүргийг хэрхэн, яаж олгох боломжтойг тодорхойлоход чухал үүрэгтэй. Эдэлбэртэй холбоотой олон асуудлууд муу засаглалаас улбаатай байдаг ба эдэлбэртэй холбоотой асуудлуудын шийдвэрлэлт засаглалын чанараас шалтгаалдаг. Муу засаглал нь нийгмийн тогтвортой байдал, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, хөрөнгө оруулалт болон эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлдөг. Эдэлбэрийн үйл ажиллагаа авилгад өртөж, хэрэгжүүлэгч агентлагууд хүмүүсийн эдэлбэрийн эрхийг хамгаалж чадахгүй бол хүмүүс орон байргүй болж, газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрхээ алдаж амьжиргааны эх сурвалжгүй болж өлсгөлөн, ядууралд нэрвэгдэж хүрнэ. Эдэлбэрийн сул дорой засаглал хүч хэрэглэсэн зөрчилдөөнд хүргэж улмаар хүмүүс амь насаараа хохирч ч болзошгүй юм. Харин эдэлбэрийн хариуцлагатай засаглал нь эсрэгээрээ нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгож, ядуурал, хүнсний аюултай байдлыг арилгахад туслаж хариуцлагатай хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмждэг.

Өсөн нэмэгдэж буй түгээмэл сонирхлыг харгалзан үзэж НҮБ-ын ХХААБ болон түүний түнш байгууллагууд эдэлбэрийн хариуцлагатай засаглалын сайн дурын зөвлөмж боловсруулах ажлыг санаачлан эхлүүлсэн юм. Энэхүү санаачлагыг ХХААБ-ын Зөвлөлийн 2004 оны 11 дүгээр сарын нэг зуун хорин долоодугаар чуулган болон 2006 оны Хөдөө аж ахуйн шинэчлэл, хөдөөгийн хөгжлийн олон улсын хурлаар (ICARRD) баталсан Үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд зохистой хүнсээр хангагдах эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх сайн дурын зөвлөмжид (Хоол, хүнсээр хангагдах эрхийн тухай сайн дурын зөвлөмж) үндэслэн, түүний хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор гаргасан болно.

Дэлхийн хүнсний аюулгүй байдлын хорооны (ДХАБХ) 2010 оны 10 дугаар сарын гучин зургаадугаар чуулганаар энэхүү зөвлөмжийг ДХАБХ-д өргөн барьж хэлэлцүүлэн, батлуулах зорилгын үүднээс тус зөвлөмжийг

боловсруулах өргөн хүрээтэй үйл явцыг үргэлжлүүлэхийг дэмжиж, зөвлөмжийн анхны төслийг хянан тохиолдуулах ДХАБХ-ны нээлттэй ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн.

Энэхүү зөвлөмжийг хариуцлагатай үйл ажиллагааны зарчим, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнүүдийг тогтоосон ХХААБ-ын бусад сайн дурын бичиг баримтын форматын дагуу боловсруулсан болно. Үүнд: Хүнсээр хангагдах эрхийн тухай сайн дурын зөвлөмж; Хариуцлагатай загасны аж ахуйн зөвлөмж; Пестицидийн ашиглалт ба хуваарилалтын зөвлөмж; Тарьмал ойн хариуцлагатай менежмент: Сайн дурын зөвлөмж; Гал түймрийн менежментийн сайн дурын зөвлөмж: Зарчмууд ба стратегийн үйл ажиллагаа. Эдгээр нь стратеги, бодлого, хууль, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад ашиглаж болохуйц үндсэн санаануудыг агуулсан харьцангуй богино хэмжээний бичиг баримтууд юм. Шаардлагатай тохиолдолд ашиглах зорилгоор тодорхой асуудлаар техникийн дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан нэмэлт зөвлөмжүүд, сургалт, сурталчилгааны материалууд болон хэрэгжилтийн удирдамж зэрэг өргөн хүрээний туслах баримт бичгүүдийг нэмэлтээр гаргасан болно.

Энэхүү зөвлөмжийг ДХАБХ-ны 2012 оны 5 дугаар сарын 11-ний гучин наймдугаар (тусгай) чуулганаар баталсан юм.

Тус зөвлөмжийг нээлттэй ажлын хэсгийн 2011 оны 6, 7, 10 дугаар сар, 2012 оны 3 дугаар сарын уулзалтуудаар боловсруулсан бөгөөд 2009-2010 онд болсон өргөн хүрээний зөвлөлдөх уулзалтаар хянан хэлэлцсэн. Бүсийн зөвлөгөөнийг Бразил, Буркина, Фасо, Этиоп, Жордан, Намиб, Панам, Румын, ОХУ, Самоа, Вьетнамд хийсэн бөгөөд төр, хувийн хувшил, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдыг төлөөлсөн 133 орны 700 гаруй хүн оролцсон. Африк (Мали), Ази (Малайз), Европ болон Төв Ази (Итали) Латин Америк (Бразил)-ийн иргэний нийгмийнхэний оролцоотой 4 удаагийн тусгай зөвлөгөөнийг зохион байгуулахад 70 гаруй орны 200 гаруй төлөөлөгч оролцсон. Хувийн хэвшлийн нэмэлт зөвлөгөөнд 21 орны 70 гаран төлөөлөгч оролцсон. Энэхүү зөвлөмжинд анхны хувилбарын талаар цахимаар ирүүлсэн саналуудыг мөн тусгасан. Анхны хувилбарыг сайжруулах саналуудыг дэлхийн өнцөг булан бүрээс төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэн судлаачид ирүүлсэн юм.

Энэхүү зөвлөмжийг хүний эрх болон эдэлбэрийн эрхийн талаар тусгасан Мянганы Хөгжлийн Зорилтууд зэрэг олон улсын болон бүс нутгийн баримт бичгүүдийн үзэл санаанд нийцүүлэн болон тэдгээрт тулгуурлан боловсруулсан болно. Эдэлбэрийн засаглалыг сайжруулах зорилгоор энэхүү зөвлөмжийг уншиж байгаа хүмүүс дээрхи бичиг баримтыг байнга үзэж хүлээсэн үүрэг, сайн дурын гэрээний талаар нэмэлт удирдамж авч болох юм.

Эхлэл

1. Зорилго

1.1 Энэхүү сайн дурын зөвлөмжийн зорилго нь газар², загас, ойн нөөцийн эдэлбэрийн засаглалыг сайжруулахад оршино. Зөвлөмж нь нийт хүмүүс, ялангуяа эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн ашиг сонирхолд үйлчлэх хийгээд хүнсний аюулгүй байдал, шаардлагатай хүнсээр хангагдах эрхийн баталгааг системтэйгээр бүрдүүлэх, ядуурлыг арилгах, тогтвортой амьжиргаа, нийгмийн тогтвортой байдал, орон сууцны баталгаа, хөдөөгийн хөгжил, байгаль хамгаалал болон нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгыг агуулсан болно. Энэхүү зөвлөмжийн дагуу эдэлбэрийн засаглалыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж буй бүх хөтөлбөр, бодлого болон мэргэжлийн туслалцаа нь улс орнуудын олон улсын хуулийн дагуу тухайлбал Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон олон улсын бусад хүний эрхийн баримт бичгийн дагуу хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг хариуцлагатай нь нийцсэн байна.

1.2 Зөвлөмжид дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Газар, загас, ойн нөөцийг ашиглах, эзэмших, хянах эрхийн зохицуулалтын системийн талаарх олон улсын практикт хүлээн зөвшөөрөгдсөн удирдамж, мэдээллээр хангаж эдэлбэрийн засаглалыг сайжруулах.
2. Байгалийн нөөцийн эдэлбэрийн олон төрлийн эрхийн зохицуулалтын талаарх бодлого, эрх зүй, бүтэц зохион

2 Эдэлбэр гэсэн утгын хүрээнд газрын тухай олон улсын хэмжээнд тохирсон тодорхойлолт байдаггүй. Энэ үгийн утгыг үндэсний түвшинд тодорхойлж ойлговол зохино.

байгуулалтыг боловсронгуй болгож, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах.

3. Нөөцийн эдэлбэрийн системийн ил тод байдлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь сайжруулах.
4. Хэрэгжүүлэгч агентлагууд; тухайлбал шүүх байгууллагууд; орон нутгийн захиргаад; фермерүүд, жижиг үйлдвэрлэгчид, загас болон ойн аж ахуй эрхлэгчдийн холбоод; малчид; уугуул болон бусад иргэд; иргэний нийгмийн байгууллагууд; хувийн хэвшлийнхэн; эрдэмтэн судлаачид болон эдэлбэрийн засаглалтай хамааралтай бусад бүх хүмүүсийн чадамж, үйл ажиллагааг сайжруулах, тэдний хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих.

2. Шинж чанар ба хамрах хүрээ

- 2.1. Энэхүү зөвлөмж нь сайн дурынх болно.
- 2.2. Энэхүү зөвлөмжийг үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нийцүүлэн тайлбарлаж хэрэгжүүлэх нь зүйтэй. Зөвлөмж нь хүний эрхийн талаарх болон газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн баталгаат эрхийг хангахад чиглэсэн үндэсний, бүсийн болон олон улсын хэмжээний санал, санаачлагууд мөн түүнчлэн засаглалыг сайжруулах зорилго бүхий санал, санаачлагуудыг баяжуулан дэмжиж байгаа юм. Уг зөвлөмжид төрийн олон улсын хуулиар хүлээсэн эрх зүйн аливаа үүргийг хязгаарласан, түүнд халдсан зүйл огтоос үгүй болно.
- 2.3. Зөвлөмжийг төр; тухайлбал шүүх байгууллагууд; орон нутгийн захиргаад; фермерүүд, жижиг үйлдвэрлэгчид, загас болон ойн аж ахуй эрхлэгчдийн холбоод; малчид; уугуул болон бусад иргэд; иргэний нийгмийн байгууллагууд; хувийн хэвшлийнхэн; эрдэмтэн судлаачид болон эдэлбэрийн засаглалд үнэлгээ өгч, сайжруулах арга замуудыг тодорхойлж тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн бүхий л хүмүүс ашиглаж болно.
- 2.4. Зөвлөмж нь цар хүрээгээрээ дэлхий нийтийг хамарсан баримт бичиг юм. Эдийн засгийн хөгжлийнхөө аль ч үе шатанд явж буй улс орнууд, бүс нутгууд болон төрийн, хувийн, нийтийн, хамтын, уугуул болон уламжлалт зэрэг бүхий л хэлбэрийн эдэлбэрийн засаглалын хүрээнд уг зөвлөмжийг үндэсний онцлогтоо тохируулан ашиглах боломжтой.
- 2.5. Зөвлөмжийг үндэсний эрх зүйн систем болон түүний бүтэц бүрэлдэхүүнд нийцүүлэн ойлгож, ашиглах нь зүйтэй.

Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн засаглалын эрх, үүрэг хариуцлагатай холбоотой асуудлууд; тухайлбал бодлого, эрх зүйн болон бүтэц-зохион байгуулалтын хамрах хүрээ; мөн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуудлуудыг авч үзнэ.

Эдэлбэрийн засаглалын хүрээнд улс орнууд холбогдох олон улсын хүний эрхийн баримт бичгийн хүрээнд хариуцлага хүлээж байдаг. Бүлэг 2-ыг 2.2-т заасны дагуу ойлгох нь зүйтэй.

3. Эдэлбэрийн хариуцлагатай засаглалын үндсэн зарчим

ЗА Ерөнхий зарчмууд

3.1 Төр:

1. Зүй ёсны эдэлбэрийн эрх эзэмшигчид, тэдний эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэнэ. Албан ёсны бүртгэлтэй эсэхээс үл хамааран зүй ёсны эдэлбэрийн эрх эзэмшигчид болон тэдний эрхийг тодорхойлж, бүртгэн, хүндэтгэх талаар болон бусдын эдэлбэрийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх; эдэлбэрийн эрхтэй холбоотой үүргийг биелүүлэх талаар ухаалаг арга хэмжээ авах хэрэгтэй.
2. Зүй ёсны эдэлбэрийн эрхийг элдэв аюул занал, зөрчлөөс хамгаална. Төр эдэлбэрийн эрх эзэмшигчдийн эрх зохисгүйгээр алдах тухайлбал үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүргийг зөрчин албадан нүүлгэж эдэлбэрийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хамгаалах үүрэгтэй.
3. Зүй ёсны эдэлбэрийн эрхээ эдлэх явдлыг дэмжиж боломжоор

хангана. Эдэлбэрийн эрхээ бүрэн эдлэх явдлыг дэмжиж нөхцөл бололцоогоор хангах талаар идэвхитэй арга хэмжээ авах ба эрхийг шилжүүлэх тохиолдолд нийтэд хүртээмжтэй үйлчилгээгээр хангах зэргээр шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж өгөх хэрэгтэй.

4. Зүй ёсны эдэлбэрийн эрхийн зөрчлийг шүүхээр шийдвэрлүүлэх боломжоор хангана. Хүн бүрт, шүүхээр болон бусад хэлбэрээр эдэлбэрийн эрхийн маргаантай асуудлаа шийдвэрлүүлэх үр дүнтэй боломжийн арга замыг санал болгож гарсан шийдвэрийг боломжийн байдлаар шуурхай хэрэгжүүлэх боломж олгох нь зүйтэй. Нийтийн хэрэгцээний зориулалтаар эдэлбэрийн эрх цуцлагдсан тохиолдолд төрөөс зохих нөхөн олговрыг шуурхай олгоно.
 5. Эдэлбэрийн эрхийн маргаан, хүч хэрэглэсэн мөргөлдөөн, авлигаас урьдчилан сэргийлнэ. Эдэлбэрийн эрхийн маргаан үүсэхээс, улмаар хүч хэрэглэсэн мөргөлдөөн болж хувирахаас урьдчилан сэргийлж идэвхитэй арга хэмжээ авах хэрэгтэй. Мөн бүх шатанд, бүх хэлбэрээр, бүх төрлийн авлигаас урьдчилан сэргийлэхийг хичээх нь зүйтэй.
- 3.2 Бизнес эрхлэгчид зэрэг төрийн бус оролцогчид хүний эрх болон зүй ёсны эдэлбэрийн эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ. Бизнесийн байгууллагууд бусдын хүний эрх болон зүй ёсны эдэлбэрийн эрхийг зөрчихөөс зүй ёсоор хичээнгүйлэн зайлсхийх хэрэгтэй. Хүний эрх болон зүй ёсны эдэлбэрийн эрхэд сөрөг нөлөө учруулахаас сэргийлж, асуудлыг шийдвэрлэх үүднээс эрсдлийн зохистой менежментийн системтэй байвал зохистой. Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа шууд болон шууд бусаар хүний эрх болон зүй ёсны эдэлбэрийн эрхэд сөрөг нөлөө үзүүлсэн буюу үзүүлэхэд хүргэсэн тохиолдолд, зөрчлийг арилгах шүүхийн бус механизмыг санал болгон хамтран ажиллах ба зүйд нийцсэн тохиолдолд, санал гомдлыг шуурхай хэлэлцэн шийдвэрлэх арга хэмжээ авах нь зүйтэй. Бизнесийн байгууллагууд өөрсдөө хамааралтай байх тохиолдолд хүний эрх болон зүй ёсны эдэлбэрийн эрхэд учруулсан бодит болон боломжит сөрөг нөлөөг тодорхойлж үнэлгээ өгөх нь зүйтэй. Төр олон улсын үүрэг хариуцлагынхаа хүрээнд хүний эрх болон хууль ёсны эдэлбэрийн эрхэд сөрөг нөлөө үзүүлсэн бизнесийн байгууллагуудад хуулийн хариуцлага хүлээлгэж хохирлыг үр дүнтэй шүүхийн шийдвэрээр барагдуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Үндэстэн дамнасан корпорациуд зөрчил гаргасан тохиолдолд бизнесийнхэн хүний эрх болон зүй ёсны эдэлбэрийн эрхийн зөрчил гаргахгүй байх тал дээр тухайн корпорациуд болон хүлээн авагч орны аль алинд нь туслалцаа үзүүлэхэд корпорацийн эх орон чухал үүрэгтэй. Төрийн өмчит болон төрийн оролцоотой бизнесийн байгууллагууд болон

төрийн агентлагуудаас бодит дэмжлэг үйлчилгээ авдаг бизнесийн байгууллагууд хүний эрх болон зүй ёсны эдэлбэрийн эрхийн зөрчил гаргахаас сэргийлж төрөөс нэмэлт арга хэмжээ авах нь зүйтэй.

ЗБ Хэрэгжилтийн зарчмууд

Эдгээр хэрэгжилтийн зарчмууд нь газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалыг хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

1. Хүний нэр төр: Хувь хүн бүрийн халдашгүй, тэгш эрх болон төрөхөөс заяагдмал нэр төрийг хүлээн зөвшөөрнө.
2. Алагчлахгүй байх: Хэн ч хуулийн болон бодлогын хүрээнд төдийгүй бодит амьдрал дээр алагчлагдах ёсгүй.
3. Тэгш эрх ба шударга ёс: Хувь хүмүүст тэгш эрх эдлэх боломж олгохын тулд тэдний хоорондын ялгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг ухамсарлаж, үндэсний хэмжээнд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн тэгш эрхээр хангаж, бүх хүмүүст түүний дотор эмэгтэй, эрэгтэй хүмүүс, залуучууд, эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан бүлгийн хүмүүст боломж олгохын тулд эрх болон боломжийн цар хүрээг тэлэх зэрэг нааштай арга хэмжээ авах шаардлагатай.
4. Жендерийн эрх тэгш байдал: Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондын ялгааг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр эмэгтэй, эрэгтэй хүмүүст хүний эдлэх ёстой бүхий л эрхийг тэгш эдлэх боломж олгож, шаардлагатай тохиолдолд тэгш эрхээ амьдралд бодитоор эдлэх боломжоор хангах явдлыг эрчимжүүлэхэд чиглэсэн тусгай арга хэмжээ авах. Төрөөс охид, эмэгтэйчүүдийн иргэний болон гэр бүлийн байдлаас үл хамааран тэдэнд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн тэгш эрх болон боломж олгох нь зүйтэй.
5. Цогц, тууштай хандлага: Байгалийн нөөц түүний ашиглалт нь харилцан уялдаатай гэдгийг хүлээн зөвшөөрч нөөц ашиглалтын удирдлагын цогц, тууштай чиг шугамыг хэрэгжүүлнэ.
6. Зөвлөгөөн, оролцоо: Зүй ёсны эдэлбэрийн эрх эзэмшдэг, эрхийнх нь хэрэгжилтэнд гаргаж буй шийдвэр нөлөөлж болзошгүй хүмүүстэй хамтран ажиллаж тийм шийдвэр гарахаас өмнө тэдний дэмжлэгийг олж авах арга замыг хайж, тэдний саналыг харгалзан үзнэ; өөр өөр талуудын хоорондын эрх мэдлийн харилцан адилгүй байдлыг харгалзан үзэж холбогдох шийдвэр гаргах үйл явцад хувь хүмүүс болон бүлгүүдийн идэвхитэй, эрх чөлөөтэй, үр дүнтэй, утга учиртай, мэдээлэлд тулгуурласан оролцоог хангана.
7. Хууль дүрэм: Зохих ёсны хэл дээр нийтэд мэдээлэгдсэн, бүх нийтээр дагаж мөрдөх, бие даасан шүүхэд эрх тэгш байдлаар ашиглагддаг, үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин

төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн үүрэг амлалтуудтай нийцсэн хуулиудад үндэслэсэн хууль ёсны чиг шугамыг баримтлана.

8. Ил тод байдал: Ойлгомжтойгоор бичигдэж, зохих ёсны хэл дээр нийтэд мэдээлэгдсэн бодлого, хууль, дүрэм журам болон зохих ёсны хэл дээр нийтэд мэдээлэгдсэн шийдвэрүүдийг бүх нийтэд хүртээмжтэй хэлбэрээр гаргана.
9. Хариуцлагатай байдал: Хувь хүмүүс, төрийн агентлагууд болон төрийн бус оролцогч талууд өөрсдийн гаргаж буй үйлдэл, шийдвэртээ хуулийн өмнө хариуцлага хүлээдэг байх.
10. Байнга боловсронгуй болгох: Төрөөс бодит баримтанд тулгуурласан хөтөлбөр боловсруулж цаашид улам бүр сайжруулахын тулд эдэлбэрийн засаглалын хяналт, дүн шинжилгээний механизмыг боловсронгуй болгон сайжруулах шаардлагатай.

4. Эдэлбэртэй холбоотой эрх, үүргүүд

- 4.1. Газар, загас, ойн нөөц нь хүний эрхийн хэрэгжилт, хүнсний аюулгүй байдал, ядуурлыг бууруулах, тогтвортой амьжиргаа, нийгмийн тогтвортой байдал, орон сууцны баталгаа, орон нутгийн хөгжил, нийгэм, эдийн засгийн өсөлтийг хангахад голлох үүрэгтэй учраас төрөөс эдэлбэрийн хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэхийг эрмэлзэх нь зүйтэй.
- 4.2. Төр эдэлбэр, эдэлбэрийн засаглалтай холбоотой бүхий л үйл ажиллагаа тэдний үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцэж байх тал дээр анхаарах үүрэгтэй.
- 4.3. Бүх талууд эдэлбэрийн эрх түүний дотор хувийн өмчлөл нь туйлын эрх биш гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Эдэлбэрийн бүхий л эрх нь бусдын эрх болон төрөөс нийтийн зайлшгүй хэрэгцээний зориулалтаар хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээр хязгаарлагдана. Эдгээр арга хэмжээ нь байгаль орчны хамгаалал зэрэг зөвхөн нийтийн сайн сайхныг дэмжих зорилгын үүднээс хуулиар тодорхойлогдсон байх ба төрийн хүний эрхийн талаар хүлээсэн үүргүүдтэй нийцсэн байна. Мөн эдэлбэрийн эрхүүд нь дагалдах үүргүүдтэй байна. Бүх нийтээрээ газар, загас, ойн нөөцийн урт хугацааны хамгаалалт, тогтвортой ашиглалтыг хүндэтгэн үзэх ёстой.
- 4.4. Төр үндэсний хууль дүрмийн дагуу эдэлбэрийн эрхийн хэрэгжилтийн хяналт дээр үндэслэн хуулиар хараахан хамгаалагдаагүй байгаа зүй ёсны эдэлбэрийн эрхийг хууль эрх зүйн үүднээс баталгаажуулах үүрэгтэй. Эдэлбэрийн эрхийг хангах бодлого, хуулиуд нь алагчлалаас ангид, жендерийн мэдрэмжтэй

байх ёстой. Төр энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн болон оролцооны зарчмын дагуу зүй ёсныд тооцогдох эрхийн төрлүүдийг нийтэд ил болгосон дүрэм журмаар дамжуулан тодорхойлно. Эдэлбэрийн бүхий л хэлбэрүүд нь төрийн үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүргүүдтэй үл нийцэх байдлаар хүмүүсийг албадан нүүлгэх, болон зүй бус үйлдэл, бусад аюул заналаас хүмүүсийг хууль ёсоор тодорхой хэмжээнд хамгаалах эдэлбэрийн баталгаагаар хангана.

- 4.5. Төр зүй ёсны эдэлбэрийн эрхийг хамгаалах үүрэгтэй хийгээд хүмүүсийг зохисгүйгээр албадан нүүлгэхээс сэргийлж, тэдний зүй ёсны эдэлбэрийн эрх өөр ямар нэгэн байдлаар цуцлагдах болон зөрчигдөхөөс хамгаалах үүрэгтэй.
- 4.6. Төрөөс эдэлбэрийн эрхтэй холбоотой тухайлбал гэрлэлтийн байдалд өөрчлөлт орсон, эрх зүйн чадамж алдагдсан, эдийн засгийн нөөц бололцооны хүртээмж муудсан зэрэгтэй холбоотой алагчлах явдлын бүхий л хэлбэрийг арилгах, хориглох ёстой. Тухайлбал, төрөөс эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эдэлбэрийн тэгш эрхийг хангаж, эдгээр эрхийг өвлүүлэн шилжүүлэх, гэрээслэн үлдээх эрхийг хангах үүрэгтэй. Төрийн эдгээр арга хэмжээ нь түүний үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай зохицсон байна.
- 4.7. Эдэлбэрийн эрхээ амьжиргааны баталгаа болгон өөрсдөө хөөцөлдөн олж авах, хэрэгжүүлэгч агентлаг болон шүүх байгууллагын тусламжтайгаар олж авах, эсхүл өөрсдийнх нь эдэлбэрийн эрхэд нөлөөлж болзошгүй үйл явцад оролцох чадваргүй хүмүүст алагчлалгүй, жендерийн мэдрэмжтэй туслалцаа үзүүлэх талаар төрөөс бодолцох ёстой.
- 4.8. Хүний бүхий л эрх нийтлэг, салшгүй, харилцан хамааралтай, харилцан холбоотой учир газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн засаглалд газар, загас, ойн нөөцийн хүртээмж, ашиглалттай шууд холбоотой эрхүүдийг төдийгүй мөн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын холбоотой бүхий л эрхүүдийг адилхан харгалзан үзэх шаардлагатай. Ингэхдээ төрөөс хүний эрхийг хамгаалагчдын иргэний болон улс төрийн эрхүүд тухайлбал тариаланчид, уугуул иргэд, загасчид, мал аж ухай эрхлэгчид болон хөдөө ажилладаг хүмүүсийн эрхийг хүндэтгэн хамгаалж, газар, загас, ойн нөөцийг хамгаалах чиглэлээр ажилладаг хувь хүмүүс болон холбоодтой харьцахдаа тэдний хүний эрхийн үүрэг хариуцлагыг харгалзан үзэх хэрэгтэй.
- 4.9. Төрөөс эдэлбэрийн эрхтэй холбоотой маргааныг шударга, чадварлаг шүүх захиргааны байгууллагаар дамжуулан шуурхай,

боломжийн, үр дүнтэй аргыг ашиглан олон хувилбараар шийдвэрлэх боломж олгож, зөрчлийг үр дүнтэй хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд давж заалдах эрх олгох хэлбэрээр шийдвэрлэх боломж бололцоог бүрдүүлэх нь зүйтэй. Эдгээр зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авах хэрэгтэй ба эрх сэргээх, учирсан бодит хохирлын нөхөн төлбөр, нөхөн олговор олгох, хохирол барагдуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч болно. Энэхүү зөвлөмжийн 6.6 ба 21.6-д заасны дагуу төрөөс эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан хүмүүст дурьдсан арга хэрэгслүүдийг хүртээмжтэй байлгах талаар онцгой анхаарах хэрэгтэй. Төр эдэлбэртэй холбоотойгоор хүний эрх нь зөрчигдсэн хэнд ч болов маргаан шийдвэрлэх, зөрчлийг арилгах дээрхи арга хэрэгслүүд хүртээмжтэй байх боломжийг хангах үүрэгтэй.

- 4.10. Төр эдэлбэрийн засаглалын оролцооны үйл явцад бүрэн хамааралтай байхын тулд газар, ой, загасны нөөц ашиглагчдын оролцоог дэмжиж үндэсний хууль дүрэм, журмын дагуу төрийн болон төрийн бус оролцогчдын үүрэг хариуцлагын хүрээнд нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого, хууль боловсруулах, хэрэгжүүлэх, шийдвэр гаргах зэрэгт тэдний оролцоог хөхүүлэн дэмжих нь зүйтэй.

5. Эдэлбэртэй холбоотой бодлого, эрх зүйн болон бүтэц-зохион байгуулалтын тогтолцоо

- 5.1 Төрөөс газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалыг дэмжсэн бодлого, эрх зүй, бүтэц-зохион байгуулалтын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр тогтолцоо нь эрх зүйн системийн, төрийн үйлчилгээний болон шүүх байгууллагуудын өргөн хүрээний шинэчлэлүүдээс хамааралтай төдийгүй ийм шинэчлэлүүдээр дэмжигдэж байдаг.
- 5.2 Төрөөс эдэлбэрийн засаглалын бодлого, эрх зүй, бүтэц-зохион байгуулалтын тогтолцоо нь үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүс нутгийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай мөн адил уялдаатай байх талаар анхаарах хэрэгтэй.
- 5.3 Төрөөс эдэлбэрийн засаглалын бодлого, эрх зүй, бүтэц-зохион байгуулалтын тогтолцоогоор хуулиар хамгаалагдаагүй байгаа зүй ёсны эдэлбэрийн эрх тухайлбал зүй ёсны уламжлалт эдэлбэрийн эрхүүдийг үндэсний хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрч, хүндэтгэх; мөн эдэлбэрийн эрхийн биелэлтийг ханган дэмжиж хамгаалдаг байх нөхцөлийг бүрдүүлнэ. Эдгээр тогтолцоонд газар, ой, загасны нөөцийн нийгэм, соёл, эдийн засаг, байгаль орчны ач холбогдлыг тусгасан байх нь зүйтэй. Төр алагчлалаас ангид, нийгмийн болон жендерийн эрх тэгш байдлыг хангасан тогтолцоог бий болгох шаардлагатай. Эдгээр тогтолцоонд газар, загас, ойн нөөц

болон тэдгээрийн ашиглалтын харилцан уялдаатай харилцааг тусгаж, тэдгээрийн удирдлагын нэгдмэл байдлыг бий болгох шаардлагатай.

- 5.4 Төр эдэлбэр, эдэлбэрийн эрхтэй холбоотой охид, эмэгтэйчүүдэд тулгардаг онцгой саад бэрхшээлүүдийг анхааралдаа авч эрх зүй, бодлогын тогтолцоогоор эмэгтэйчүүдийг зохистой байдлаар хамгаалсан байх нөхцөлийг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн эдэлбэрийн эрхийг тусгасан хуулиудыг хэрэгжүүлж, биелүүлдэг байх тал дээр анхаарна. Төрөөс эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил эдэлбэрийн эрхтэй холбоотой гэрээ, хэлэлцээр байгуулах хууль ёсны эрх эдлэх нөхцөлийг бүрдүүлж, эмэгтэйчүүд өөрсдийн эдэлбэрийн ашиг сонирхолоо хамгаалахад нь хууль эрх зүйн үйлчилгээ болон бусад туслалцаа дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэх нь зүйтэй.
- 5.5 Төрөөс холбогдох бодлого, хууль, дүрэм журмыг боловсруулахдаа бүх хохирогч талуудыг хамруулан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг бүр эхнээс нь оролцуулах нөхцөлийг хангаж хамтын оролцооны үйл явцаар дамжуулан ажиллана. Бодлого, хууль, дүрэм журам боловсруулахдаа хэрэгжүүлэх боломжтой эсэхийг нь харгалзан үзнэ. Эдгээр бичиг баримтууд нь жендерийн мэдрэмжтэй аргаар боловсруулагдсан, зохих ёсны хэлнээ хөрвүүлэгдсэн, нийтэд мэдээлэгдсэн байх нь зүйтэй.
- 5.6 Төрөөс хүмүүст үйлчилгээг хамгийн үр дүнтэй хүргэх боломжтой засгийн газрын түвшинд хариуцлагыг хүлээлгэх ёстой. Төрөөс газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн асуудал эрхэлсэн агентлагуудын үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон байна. Төрөөс хэрэгжүүлэгч агентлагуудын хоорондын уялдаа холбоо, орон нутгийн захиргаад, эдэлбэрийн уламжлалт ёсны системтэй уугуул болон бусад иргэдтэй хамтран ажиллах зохицуулалтыг бүрдүүлнэ.
- 5.7 Төрийн зүгээс шаардлагатай тохиолдолд иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэн болон эрдэмтэн судлаачдад бодлого, эрх зүй, бүтэц-зохион байгуулалтын тогтолцоог боловсруулж, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломж боллоцоог тодорхойлж сурталчлах шаардлагатай.
- 5.8 Төр болон бусад талууд бодлого, эрх зүй, бүтэц-зохион байгуулалтын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тогтмол хянан хэлэлцэж, шалгаж байх нь зүйтэй. Хэрэгжүүлэгч агентлагууд, шүүх байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцыг ил тод байлгах замаар авилгаас урьдчилан сэргийлэх үйлчилгээ, хичээл зүтгэлээ улам бүр сайжруулах тал дээр иргэний нийгмийн байгууллагууд, үйлчлүүлэгчдийн төлөөллүүд, болон олон нийттэй хамтарч ажиллах шаардлагатай. Өөрчлөлтүүд болон тэдгээрээс хүлээгдэж буй үр дүнгийн талаар тодорхой тэмдэглэж,

зохих ёсны хэлээр нийтэд мэдээлэх хэрэгтэй.

- 5.9 Төрөөс эдэлбэрийн эрхтэй холбоотой бодлого, хууль тогтоомж нь улс төр, эрх зүй, нийгэм, соёл, шашин, эдийн засаг, байгаль орчны өргөн хүрээнд үйлчилдэг гэдгийг ухамсарлах хэрэгтэй. Эдгээр өргөн хүрээний нөхцөл байдал өөрчлөгдөж, үүний улмаас эдэлбэрийн шинэчлэл хийх шаардлагатай болсон тохиолдолд төрөөс аливаа шинэчлэлийг хийх үндэсний хэмжээний зөвшилцөлд хүрэхийг эрмэлзэх ёстой.

6. Үйлчилгээ үзүүлэх**

- 6.1 Төрөөс нөөцийн боломжийн хэрээр, хэрэгжүүлэгч агентлагууд болон шүүх байгууллагуудыг төрийн бодлого, хуулиудыг тухай бүрт нь үр дүнтэй, жендерийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх хүний нөөц, хөрөнгө санхүүгийн болон бусад төрлийн чадавхитай байх талаас нь анхаарах хэрэгтэй. Зохион байгуулалтын бүхий л түвшний ажилтнууд сургалтанд тогтмол хамрагдаж байх шаардлагатай хийгээд, хүмүүсийг ажилд авахдаа жендерийн болон нийгмийн эрх тэгш байдлын үүднээс хандах хэрэгтэй.
- 6.2 Төрөөс эдэлбэр болон түүний удирдлагатай холбоотой үйлчилгээ үзүүлэх асуудал нь түүний үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцэж байх тал дээр анхаарна.
- 6.3 Төрөөс эдэлбэрийн эрхийг хамгаалах, эдгээр эрхийн хэрэгжилтийг хангах, хөхүүлэн дэмжих болон маргаан шийдвэрлэх үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хэлбэрээр, алагчлалгүй хүргэх тал дээр анхаарна. Төрөөс эрх зүйн болон дүрэм журмын хэрэгцээгүй шаардлагуудыг хасч, эдэлбэрийн эрхтэй холбоотой саад бэрхшээлийг арилгах талаар арга хэмжээ авна. Төрөөс хэрэгжүүлэгч агентлагууд, шүүх байгууллагуудын үйлчилгээг хянан үзэж, шаардлагатай тохиолдолд сайжруулна.
- 6.4 Төрөөс хэрэгжүүлэгч агентлагууд, шүүх байгууллагууд төрийн үйлчилгээг нийт хүн амд, түүний дотор алслагдсан орон нутгийн хүмүүст хүргэх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Үйлчилгээний үр дүн, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд тухайн орон нутагт зохицсон техник технологийг ашиглан үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хэлбэрээр хүргэнэ. Төрийн үйлчилгээний ажилтнууд бодлого, хуулиудыг найдвартай, тууштай хэрэгжүүлэх боломжтой байх үүднээс дотоод дүрэм, журам зааварчилгаагаар хангах нь зүйтэй. Эдэлбэрийн баталгаа болон шударга ёсонд халгүйгээр дүрэм журмыг хялбаршуулах хэрэгтэй. Тайлбар материалуудыг зохих ёсны хэлээр олон нийтэд сурталчлан таниулж, хэрэглэгчдэд эрх, үүрэг хариуцлагынх нь талаар мэдээлэл хийнэ.

** дугаар зүйлийг тусгайлан 17-21 дүгээр зүйлүүдтэй холбон ойлгоно.

- 6.5 Төрөөс эдэлбэрийн эрхтэй холбоотой зохих орон зайн болон бусад мэдээллийг төр, түүний хэрэгжүүлэгч агентлагууд, уугуул болон бусад иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэн, эрдэмтэн судлаачид, олон нийт үр дүнтэйгээр ашиглаж, солилцохыг дэмжсэн бодлого, хуулиудыг боловсруулах хэрэгтэй. Бүсийн болон олон улсын стандартуудыг үндэслэн мэдээлэл солилцооны үндэсний стандартыг боловсруулах шаардлагатай.
- 6.6 Төр болон бусад талууд ямар нэгэн өөр хэлбэрээр захиргааны болон шүүхийн үйлчилгээ хүртэх боломжгүй эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан бүлгийн хүмүүст дэмжлэг үзүүлэх нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар бодолцох шаардлагатай. Үүнд тухайлбал, боломжийн өртөгтэй эрх зүйн туслалцаа зэрэг эрх зүйн дэмжлэг үзүүлэх, мөн түүнчлэн туслах хуульч, судалгааны туслах ажилтнуудын үйлчилгээ, алслагдмал орон нутгийнхан болон нүүдэлчин уугуул иргэдэд зориулсан явуулын үйлчилгээний тухай заалтууд байж болно.
- 6.7 Төрөөс хэрэгжүүлэгч агентлагууд болон шүүх байгууллагуудад соёлтой, ёс зүйтэй байдлаар үйлчилгээ үзүүлдэг болоход нь дэмжлэг туслалцаа үзүүлнэ. Хэрэгжүүлэгч агентлагууд болон шүүх байгууллагууд үйлчлүүлэгчдийнхээ хүлээлтэнд нийцүүлэн, шинээр бий болж буй эрэлт хэрэгцээг хангах үүднээс стандартаа сайжруулж, үйлчилгээнийхээ нийлүүлэлтийг сайжруулах зорилгоор судалгаа, зорилтот бүлгийн уулзалтаар дамжуулан үйлчлүүлэгчдийнхээ санал бодлыг тогтмол сонсож байх шаардлагатай. Гүйцэтгэлийн стандартыг нийтэд ил тод болгож, үр дүнгийн талаар тогтмол мэдээлж байх нь зүйтэй. Үйлчлүүлэгчид санал гомдлоо хэрэгжүүлэгч агентлагийн дотоодын хүрээнд тухайлбал, захиргааны хяналт-шалгалтын хэлбэрээр, эсхүл гадны, бие даасан байгууллагын хяналт-шалгалт, эсхүл омбудсменаар дамжуулан шийдвэрлүүлэх боломжтой байх шаардлагатай.
- 6.8 Эдэлбэртэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг холбогдох мэргэжлийн холбоод нь үйлчилгээний ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоон, олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжилтэнд нь хяналт тавьдаг байх нь зүйтэй. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд зохих ёс зүйн стандартыг мөрдөж зөрчил гарсан тохиолдолд сахилгын хариуцлага хүлээдэг байх хэрэгтэй. Ийм мэргэжлийн холбоод байхгүй тохиолдолд тэдгээрийг үүсгэн байгуулах таатай нөхцөлийг төрөөс бий болгох ёстой.
- 6.9 Төр болон төрийн бус оролцогчид эдэлбэртэй холбоотой авилгаас урьдчилан сэргийлэх талаар хүчин чармайлт тавих үүрэгтэй. Төрийн зүгээс ялангуяа зөвлөгөөн ба оролцоог дэмжих, хууль дүрмийг сахиулах, ил тод, хариуцлагатай байх зарчмыг дэлгэрүүлэх зэрэг арга хэмжээг авч болно. Төрөөс тайлан тэнцлийг хянаж шалгах, эрх мэдлийг хэтрүүлэн ашиглах явдлыг хязгаарлах, ашиг сонирхлын

зөрчлийг арилгах, тодорхой дүрэм, журам гаргах зэрэг авилгын эсрэг арга хэмжээнүүдийг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй. Төрөөс хэрэгжүүлэгч агентлагуудын гаргасан шийдвэрүүдэд захиргааны болон хууль хяналтын байгууллагаар хяналт шалгалт хийлгүүлж болно. Эдэлбэрийн захиргааны ажилтнууд өөрсдийн үйлдэлдээ бүрэн хариуцлага хүлээнэ. Тэднийг үүргээ зохих ёсоор үр дүнтэй биелүүлэх арга хэрэгслээр хангана. Тэд ажил үүргээ гүйцэтгэхэд нь хөндлөнгөөс саад болох, мөн авилгын үйлдлийг мэдээлснийх нь төлөө өс хонзон авах явдлаас хамгаалагдсан байна.

Эдэлбэрийн эрх, үүргийн хуваарилалт ба хуулийн зохицуулалт

Энэ бүлэгт уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн эрх мөн албан бус эдэлбэрийн эрхийг хууль ёсоор баталгаажуулахтай холбоотой газар, ой, загасны нөөцийн эдэлбэрийн засаглалын тухай болон төрийн өмчийн болон төрийн оролцоотой газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрхийн анхны хуваарилалтын тухай өгүүлэх болно.

7. Баталгаа

- 7.1 Төрөөс газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрхийг хуульчлан баталгаажуулах болон олгохдоо хуулиар хараахан баталгаажуулаагүй зүй ёсны эдэлбэрийн эрх зэрэг бусдын эдэлбэрийн эрх зөрчигдөхөөс болон цуцлагдахаас хамгаалах баталгааг үндэсний хууль тогтоомжийн дагуу бий болгох ёстой. Ялангуяа, хураах эрх гэх мэт эдэлбэрийн дагалдагч эрхүүдийг эзэмшдэг эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг хамгаалах баталгаа хэрэгтэй.
- 7.2 Төр эдэлбэрийн эрх, үүргийг хуульчлан баталгаажуулж олгох бүхий л үйл ажиллагааг үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтайгаа нийцүүлэн хэрэгжүүлнэ.

- 7.3 Төрөөс эдэлбэрийн эрх, үүргийг хуульчлан баталгаажуулах эсхүл олгохдоо бүртгэгдсэн эс бүртгэгдсэнээс үл хамааран, хүчин төгөлдөр байгаа эдэлбэрийн эрхүүд болон эрх эзэмшигчдийг юуны өмнө тодорхойлно. Уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэд, жижиг эзэмшигчид болон нөлөөлөлд өртөж болзошгүй хэнийг ч болов ЗБ.6 болон 9.9-р зүйлд заасны дагуу зөвлөлдөх үйл явцад хамруулж, 4.9 –р зүйлд тусгасны дагуу хүмүүс өөрсдийн эдэлбэрийн эрхээ баталгаажаагүй хэмээн үзсэн тохиолдолд төрийн зүгээс шүүхэд хандах боломжоор хангана.
- 7.4 Төрөөс шинээр хуульчлан баталгаажуулж буй эдэлбэрийн эрхийн заалтанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд адил эрх эдлэх нөхцлийг тусгаж, эдгээр эрхийг бүртгэлд тусгана. Боломжтой тохиолдолд, хувь хүмүүс, гэр бүлүүд, бусад нийгмийн бүлгийнхний эдэлбэрийн эрхийг хуулиар баталгаажуулан олгох ажлыг системтэйгээр явуулах хэрэгтэй бөгөөд ядуу болон эмзэг бүлгийн хүмүүст эдэлбэрийн эрхээ хуулийн дагуу баталгаажуулах боломж олгохын тулд үндэсний хэмжээний тэргүүлэх асуудлуудтай уялдуулан нэг газраас нөгөө газарт шилжин явуулах хэрэгтэй. Ялангуяа, ядуу болон эмзэг бүлгийн хүмүүст эрх зүйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Эдэлбэрийн эрхийн анхны бүртгэлийг явуулахдаа тухайлбал, эдэлбэрийн эрхийн зурагжуулалт хийхдээ ил тод байдлыг хангах үүднээс тухайн орон нутагт тохирсон аргыг хэрэглэх нь зүйтэй.
- 7.5 Төрөөс эдэлбэрийн эрхээ хуулиар баталгаажуулсан эсхүл эдэлбэрийн эрх шинээр авч байгаа хүмүүст эрхийнх нь болон үүргийнх нь талаар бүрэн дүүрэн мэдээлэл өгөх хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд, эдэлбэрийн эрхээ бүрэн эдэлж, үүргээ биелүүлэх тал дээр эдгээр хүмүүст төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 7.6 Эдэлбэрийн эрхийг хуулиар баталгаажуулах боломжгүй тохиолдолд, төр энэхүү зөвлөмжийн зарчмуудын дагуу хийгээд үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд албадан шилжүүлэх арга хэмжээнээс аль болох зайлсхийх хэрэгтэй.

8. Төрийн эзэмшлийн газар, загас, ойн нөөц

- 8.1 Газар, загас, ойн нөөц төрийн эзэмшилд эсхүл төрийн хяналтанд байгаа тохиолдолд, нийгэм, эдийн засаг, байгаль орчны өргөн хүрээний зорилтуудын хүрээнд эдгээр нөөцийн ашиглалт, хяналтын журмыг төрөөс тодорхойлно. Төрийн бүх үйл ажиллагаа нь түүний үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байх ёстой.

- 8.2 Газар, загас, ойн нөөц төрийн эзэмшилд эсхүл төрийн хяналтанд байгаа тохиолдолд, хувь хүмүүс болон нийгмийн бусад бүлгийн хүмүүс тухайлбал эдэлбэрийн уламжлалт системтэй иргэдийн зүй ёсны эдэлбэрийн эрхийг үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудынхаа дагуу төрөөс хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, хамгаалбал зохино. Дээрхи зорилгын үүднээс, зүй ёсны эдэлбэрийн эрхийн төрлүүдийг ил тод байдлын хүрээнд болон үндэсний хууль тогтоомжинд нийцүүлэн нарийвчлан тодорхойлж, нийтэд мэдээлсэн байвал зохино.
- 8.3 Төрийн өмчийн газар, загас, ойн нөөцийг хамтаар ашиглан, зохицуулж буй (зарим орнуудад нийтийн эзэмшлийн хэмээн тодорхойлогддог) нөхцлийг харгалзан тохиромжтой тохиолдолд, төрийн өмчийн газар, загас, ойн нөөц болон тэдгээрийн хамтын эзэмшил, менежментийн системийг хүлээн зөвшөөрч, хамгаалах хэрэгтэй ба энэ нь нөөцийн төрийн хуваарилалтын үйл явцад ч мөн адил хамааралтай.
- 8.4 Төр нээлттэй данс бүртгэлийн систем бий болгон ажиллуулж өөрийн эзэмшилд эсхүл хяналтанд байгаа газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн цаг үеийн мэдээллийг олон нийтэд хүргэж байхыг хичээх хэрэгтэй. Ийм бүртгэлийн системд эдэлбэрийн зохицуулалтын асуудал эрхэлсэн агентлагууд, эдэлбэрийн уламжлалт системтэй уугуул болон бусад иргэдийн зүй ёсны эдэлбэрийн эрх болон хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийг багтаасан байна. Боломжтой тохиолдолд, төрийн эдэлбэрийн эрхийг эдэлбэрийн уламжлалт ёсны системтэй уугуул болон бусад иргэд, хувийн хэвшлийн байгууллагуудын эдэлбэрийн эрхтэй хамтад нь бүртгэлийн нэг системд багтааж эсвэл нэгдмэл системээр төрийн эдэлбэрийн эрхийг дээр дурьдсан эрхүүдтэй холбож өгөх хэрэгтэй.
- 8.5 Төр өөрийн өмчлөл эсхүл хяналтанд байдаг газар, загас, ойн нөөцийн аль хэсгийг нь өөрийн мэдэлд үлдээн төрийн хэрэгцээнд ашиглан, чухам аль хэсгийг нь бусдын хэрэглээнд, ямар нөхцлөөр ашиглуулах талаар тодорхойлох хэрэгтэй.
- 8.6 Төр улсын мэдэлд байдаг газар, ой, загасны нөөцийн ашиглалт, хяналтын талаар бодлого боловсруулж, олон нийтэд сурталчлан таниулах хийгээд төрийн өмчийн газар, загас, ойн нөөцөөс олох ашгийг тэгш хуваарилах бодлого боловсруулахыг эрмэлзэнэ. Энэхүү зөвлөмжинд тусгагдсан зөвлөгөөн ба болон оролцооны зарчмын дагуу бусдын болон нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүсийн эдэлбэрийн эрхийг зөвлөлдөх үйл явцад хамруулах бодлого баримтлах талаар энэхүү бодлогод тусгах нь зүйтэй. Төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эдгээр нөөцийн зохицуулалтын

асуудал болон үүнтэй холбоотой арилжааны харилцааг үр дүнтэй, ил тод, хариуцлагатай байдлаар авч үзэх нь зүйтэй.

- 8.7 Төр эдэлбэрийн эрхийг бусдад олгох, шаардлагатай тохиолдолд, эдэлбэрийн засаглалын үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхтэй холбоотой бодлого боловсруулж, олон нийтэд мэдээлнэ. Эдэлбэрийн эрх олгох бодлогыг нийгэм, эдийн засаг, байгаль орчныг хамгаалах томоохон зорилтуудтай нийцүүлэн боловсруулна. Эдэлбэрийн эрхийг дахин олгох асуудал дээр газар, ой, загасны нөөцийг уламжлал ёсоор ашиглаж ирсэн нутгийн иргэдийг зохих ёсоор харгалзан үзэх нь зүйтэй. Бодлого боловсруулахдаа бусдын болон нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүсийн эдэлбэрийн эрхийг зөвлөлдөх, оролцох, шийдвэр гаргах үйл явцад хамруулах талаар бодолцох хэрэгтэй. Эдэлбэрийн эрхийн олголт нь газар, ой, загасны нөөцөөс хүртэх хүмүүсийн зүй ёсны эрхэнд халдаж тэдний амьжиргаанд аюул учруулахгүй байхаар бодлогод тусгаж өгөх шаардлагатай.
- 8.8 Төр эдэлбэрийн эрхийг хязгаарлагдмал хэрэгцээнд зориулан олгохоос эхлээд бүрэн өмчлүүлэх хүртэл төрөл бүрийн хэлбэрээр олгох эрхтэй. Бодлогод эдэлбэрийн эрх, эрх эзэмшигчдийн талаар өргөн хүрээнд тусгасан байна. Эрх олголтын арга хэлбэрийг түүхэн урт хугацааны ашиглалт болон бусад хэлбэрийн ашиглалт дээр үндэслэн нарийвчлан бодлогоор тодорхойлсон байна. Шаардлагатай тохиолдолд, эдэлбэрийн эрх авч байгаа хүмүүст эрхээ бүрэн эдлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Олгогдсон газар, загас, ойн нөөцөд ямарваа нэгэн хэлбэрээр хяналт тавьсан хэвээр байх эсэхээ төр өөрөө тодорхойлно.
- 8.9 Төр эдэлбэрийн эрх олгож, эдэлбэрийн засаглалыг шилжүүлэхдээ ил тод, оролцооны аргаар, бүх нийтэд ялангуяа, уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдэд тодорхой, хүртээмжтэй, ойлгомжтой байх энгийн дүрэм, журмыг мөрдөж ажиллах нь зүйтэй. Мэдээллийг зохих ёсны хэлээр жендерийн мэдрэмжтэй мессэж илгээх зэрэг аргаар боломжит бүх оролцогчдод хүргэнэ. Боломжтой тохиолдолд, шинээр олгосон эдэлбэрийн эрхийг эдэлбэрийн бусад эрхтэй хамтад нь нэг системд бүртгэх эсхүл нэгдмэл системд холбож өгнө. Төрийн болон төрийн бус оролцогч талууд эдэлбэрийн эрх олголтыг авилгаас ангид байлгах талаар цаашид хүчин чармайлт тавин ажиллах болно.
- 8.10 Төр нөөц бололцооныхоо хэрээр газар, загас, ойн нөөц хариуцсан эрх мэдэл бүхий байгууллагууд хүний нөөц, хөрөнгө, санхүү болон бусад хэлбэрийн чадамжтай байх тал дээр анхаарна. Эдэлбэрийн засаглалыг шилжүүлэх тохиолдолд үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх чадвартай байхын тулд засаглалыг шилжүүлэн авч байгаа тал нь сургалтанд хамрагдаж бусад хэлбэрийн тусламж дэмжлэгийг авах нь зүйтэй.

- 8.11 Төрөөс эдэлбэрийн эрх олгох хөтөлбөрийн үр дүн, тухайлбал хүнсний аюулгүй байдлыг хангах, ядуурлыг бууруулахад үзүүлэх жендерийн ялгавартай үр нөлөө мөн түүнчлэн эдгээр хөтөлбөрийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны талаарх зорилтуудад үзүүлэх нөлөө зэргийг нягтлан үзэж, шаардлагатай засан залруулах арга хэмжээг авах хэрэгтэй.

9. Уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэд

- 9.1 Төр болон төрийн бус оролцогч талууд уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн хувьд газар, загас, ойн нөөц нь нийгэм, соёл, шашин шүтлэг, эдийн засаг, байгаль орчин, улс төрийн чухал үнэт зүйл болохыг ойлгох ёстой.
- 9.2 Газар, загас, ойн нөөцийн өөрөө удирдах засаглал бүхий уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэд тэдгээр нөөцийг эзэмших эрх тэгш, баталгаатай, тогтвортой эрхийг дэмжин хангах ёстой ба ялангуяа, эмэгтэйчүүдэд ийм эрх тэгш хүртээмжтэй байх тал дээр онцгойлон анхаарах нь зүйтэй. Эдэлбэрийн тогтолцоо тухайлбал хамтын эдэлбэрийн системтэй холбоотой шийдвэр гаргахад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, залуучууд гээд бүх хүмүүсийг орон нутгийн эсхүл уламжлалт байгууллагуудаар дамжуулан идэвхитэй оролцуулах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд, эдэлбэрийн тогтолцооны талаар шийдвэр гаргах, эдэлбэрийн засаглалыг хэрэгжүүлэхэд нутгийн иргэдийн бүрэн дүүрэн оролцох чадавхийг нь сайжруулахад нутгийн захиргаадад дэмжлэг үзүүлнэ.
- 9.3 Төрөөс бүх үйл ажиллагаа үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нийцэж байх талаар анхаарна. Төр уугуул иргэдийн хувьд, Тусгаар тогтносон улсуудын уугуул болон овог аймгийн иргэдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 169 дүгээр конвенц, Биологийн төрөл зүйлийн тухай конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын уугуул иргэдийн эрхийг хамгаалах тухай тунхаглал зэрэгт тусгагдсан хүний эрхийг хамгаалах, дэмжих, хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлага, сайн дурын үүрэг амлалтуудаа биелүүлэх үүрэгтэй.
- 9.4 Төр үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудынхаа дагуу уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн хууль ёсны эдэлбэрийн эрхийг зохих ёсоор хүлээн зөвшөөрч, хамгаалах үүрэгтэй. Ингэж баталгаажуулахдаа зөвхөн тухайн орон нутгийн хэрэгцээнд ашиглагддаг болон хамтын эзэмшилд байдаг газар, ой, загасны нөөцийг харгалзан үзэж, хариуцлагатай засаглалын

ерөнхий зарчмуудыг хүндэтгэнэ. Аливаа баталгаажуулалтын холбогдолтой мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр зохих ёсны хэл дээр буулган хүртээмжтэй байх газар байршуулан нийтэд мэдээлнэ.

- 9.5 Уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэд өвөг дээдсээс уламжлагдан ирсэн газар нутаг дээр амьдран, хууль ёсны эдэлбэрийн эрх эдэлж байгаа тохиолдолд төрөөс эл эрхийг нь хүлээн зөвшөөрч хамгаалах үүрэгтэй. Уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийг өвөг дээдсийнх өвлүүлж өгсөн газар нутгаас нь албадан нүүлгэж хэрхэвч болохгүй.
- 9.6 Төр уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн системийг баталгаажуулах бодлого, хууль, бүтэц-зохион байгуулалтыг бий болгоход анхаарна. Үндсэн хуулийн болон бусад хууль эрх зүйн шинэчлэлээр эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулсан нь уламжлалтай зөрчилдөж байгаа тохиолдолд тэдгээр өөрчлөлтийг уламжлалт эдэлбэрийн системд тусгах тал дээр бүх талууд хамтран ажиллах нь зүйтэй.
- 9.7 Төр эдэлбэрийн тухай бодлого, хуулиудын төслийг боловсруулахдаа уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн системд хамааралтай газар, загас, ойн нөөцийн нийгэм, соёл, шашин шүтлэг, эдийн засаг, байгаль орчны үнэт зүйлсийг нь харгалзан үзэх нь зүйтэй. Төрөөс уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн системтэй холбоотой бодлого, хуулиудыг боловсруулахдаа эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан бүлгийн хүмүүс гэх мэт нөлөөлөлд өртсөн иргэдийн төлөөлөл болон бүх хүмүүсийг бүрэн, идэвхитэй оролцуулах хэрэгтэй.
- 9.8 Төрөөс уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн газар, загас, ойн нөөцийг тэдний зөвшөөрөлгүй ашиглахаас хамгаална. Нутгийн иргэд зөвшөөрлийн дагуу, тэдний ашиглаж байгаа тэдний оролцоотой газар, загас, ойн нөөцийн шинж байдал, байршлын талаарх мэдээллийг албан ёсоор баримтжуулж, хэвлэн нийтлэхэд нь төрөөс туслалцаа үзүүлнэ. Уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн эрхийг албан ёсоор баримтжуулахдаа давхардсан нэхэмжлэл гарахаас сэргийлж тэдгээр эрхийг бусад төр, хувийн хэвшлийн болон бусад иргэдийн эдэлбэрийн эрхтэй хамтад нь бүртгэлжүүлэх шаардлагатай.
- 9.9 Төр болон бусад талууд нутгийн иргэдэд хамааралтай нөөцийн талаар аливаа төсөл санаачилхаасаа өмнө, мөн түүнчлэн эдгээр нөөцтэй холбоотой эрх зүйн болон захиргааны арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс өмнө уугуул иргэдтэй илэн далангүй зөвлөлдөн зөвшилцөх хэрэгтэй. Ийм төрлийн төслүүдийг уугуул иргэдийн

эрхийн тухай НҮБ-ын тунхаглалд заасны дагуу, уугуул иргэдийн эрх чөлөөтэй, урьдчилсан болон мэдээлэлд тулгуурласан зөвшөөрлийг авахын тулд өөрсдийнх нь төлөөллийн байгууллагаар дамжуулан уугуул иргэдтэй үр бүтээлтэй, утга учиртай зөвлөлдсөний үндсэн дээр тухайн улс орны онцгой байр суурь, ойлголтонд нийцүүлэн хэрэгжүүлэх ёстой. Зөвлөлдөх болон шийдвэр гаргах үйл явцыг айлган сүрдүүлэггүйгээр, итгэлцлийн уур амьсгалд зохион байгуулах хэрэгтэй. Зөвлөмжийн ЗБ.6-р зүйлд заасан зөвлөлдөх үйл явц болон оролцооны зарчмууд нь эл бүлэгт тодорхойлсон бусад иргэдэд ч мөн адил хамааралтай болно.

- 9.10 Шаардлагатай тохиолдолд, төр, төрийн бус оролцогчид нөлөөлөлд өртсөн иргэдийн төлөөллийн байгууллагууд болон нөлөөлөлд өртсөн иргэдтэй хамтран ажиллах замаар эдэлбэрийн талаарх бодлого, хууль, төслүүдийг алагчлалгүй, жендерийн мэдрэмжтэй хэлбэрээр боловсруулахад нөлөөлөлд өртсөн иргэдийг өөрсдийг нь оролцуулах тал дээр мэргэжлийн болон эрх зүйн туслалцаа үзүүлэх хэрэгтэй.
- 9.11 Төр үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэндээр хүлээсэн амлалтынхаа хүрээнд уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэртэй холбоотой хоорондын зөрчлөө шийдвэрлэхэд хэрэглэдэг уламжлалт арга хэлбэрүүдийг хүндэтгэн үзэж дэмжинэ. Нутгийн иргэдийн нэгээс илүү олон бүлэг ашигладаг газар, загас, ойн нөөцийн хувьд, бүлэг хоорондын зөрчилдөөнтэй асуудлыг шийдвэрлэх арга хэрэгслийг нь бэхжүүлж, хөгжүүлэх шаардлагатай.
- 9.12 Төр болон төрийн бус оролцогч талууд зөвлөгөөн, оролцооны зарчмаар болон иргэдийг чадавхижуулах хэлбэрээр уламжлалт эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн тогтолцоог авилгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

10. Албан бус эдэлбэр

- 10.1 Газар, ой, загасны нөөцийн албан бус эдэлбэртэй тохиолдолд, төрөөс үндэсний хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр албан ёсны эрхийг хүлээн зөвшөөрдгийн нэгэн адил, мөн бодит нөхцөл байдлыг харгалзан, нийгэм, эдийн засаг, байгаль орчны сайн сайхныг хөхүүлэн дэмжих үүднээс албан бус эрхийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Албан бус эдэлбэрийг баталгаажуулах бодлого, хуулиудыг төрөөс дэмжих нь зүйтэй. Эдгээр бодлого, хуулийг боловсруулах явцдаа иргэдийг оролцуулж, жендерийн мэдрэмжтэй байх хийгээд нөлөөлөлд өртсөн хувь хүмүүс, иргэдийн бүлэгт мэргэжлийн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх заалтыг тусгах нь зүйтэй. Ялангуяа, өргөн хүрээний шилжилт хөдөлгөөний

- үед албан бус эдэлбэрийн асуудал үүсдэг гэдгийг төрөөс хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.
- 10.2 Төрийн албан бус эдэлбэртэй холбоотой бүх үйл ажиллагаа нь шаардлага хангасан орон байраар хангах зэрэг түүний үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байх талаар анхаарна.
- 10.3 Төрөөс албан бус эдэлбэрийг хуульчлан баталгаажуулахдаа түрээслэгчдэд онцгой анхаарал хандуулж, оролцоог хангасан, жендерийн мэдрэмжтэй арга хэлбэрээр ажиллана. Ингэхдээ фермерүүд болон хүнсний жижиг үйлдвэрлэгчдэд төрөөс онцгойлон анхаарна. Эдгээр үйл явц нь хуульчлан баталгаажуулах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, зардлыг аль болох багасгахад чиглэгдэнэ. Төрийн зүгээс нутгийн иргэд болон оролцогчдод мэргэжлийн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэхийг хичээх ёстой.
- 10.4 Төрөөс газар ашиглалтыг өөрчлөх болон газар хөгжүүлэхтэй холбоотой эрх зүйн болон захиргааны хэт нарийн шаардлагын улмаас үүсэх албан бус эдэлбэрийг хязгаарлах бүхий л зохих арга хэмжээг авна. Газар хөгжүүлэхэд тавигдах шаардлагууд болон үйл явц нь ойлгомжтой, энгийн, дагаж мөрдөхөд хүндрэл бэрхшээл багатай байвал зохино.
- 10.5 Төрөөс ил тод байдлыг нэмэгдүүлж, шийдвэр гаргагчдын хариуцлагыг өндөржүүлж, аль нэг талд үйлчлээгүй шийдвэрийг цаг алдалгүй шуурхай гаргах замаар авилгаас сэргийлэхэд онцгой анхаарна.
- 10.6 Албан бус эдэлбэрийг хуулиар баталгаажуулах боломжгүй тохиолдолд, төрийн үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэгтэй нь зөрчилдсөн, энэхүү зөвлөмжийн 16-р хэсэгт заагдсан албадан нүүлгэн шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Эдэлбэрийн эрх, үүргийг шилжүүлэх болон бусад өөрчлөлтүүд

Энэ бүлэгт хөрөнгө оруулалт, газар нэгтгэл болон бусад дахин зохион байгуулалтын арга хэмжээ, эрх сэргээх, дахин хуваарилалтын шинэчлэлүүд болон эрх цуцлалтын улмаас эдэлбэрийн эрх гүйлгээнд орж, зах зээлийн замаар сайн дурын болон сайн дурын бус хэлбэрээр хүчин төгөлдөр эдэлбэрийн эрх, холбогдох үүргүүдийг шилжүүлэх, дахин олгохтой холбоотой үүсэх газар, загас, ойн эдэлбэрийн засаглалын асуудлуудыг авч үзнэ.

11. Зах зээл

11.1 Зохистой үед, шударга, ил тод борлуулалт болон түрээсийн зах зээлийг газар, загас, ойн нөөцийг ашиглах, өмчлөх эрхийг шилжүүлэх арга хэрэгсэл болгон төрөөс хүлээн зөвшөөрч дэмжинэ. Эдэлбэрийн эрхийн зах зээл үйлчилж буй нөхцөлд, бүх үйл ажиллагаа үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцэж байх талаар төрөөс анхаарна. Газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрхийн арилжаа, гүйлгээнүүд газар ашиглалтын тухай үндэсний хууль тогтоомжийн дагуу хийгдэж, хөгжлийн үндсэн зорилтуудтай зөрчилдөхгүй байх ёстой.

- 11.2 Зөрчил, тогтворгүй байдлыг багасгахын тулд ижил нөхцөл, боломжийн хүрээнд эдэлбэрийн эрхийн харилцан ашигтай байдлаар шилжүүлэх оролцоог дэмжих; газар, загас, ойн нөөцийн тогтвортой ашиглалт, байгаль хамгааллыг дэмжих; холбогдох гэрээ, хэлцлийн дагуу газар, загас, ойтой холбоотой генетикийн нөөцийг шударга, эрх тэгш байдлаар ашиглах явдлыг дэмжих; эдийн засгийн боломжуудыг нэмэгдүүлэх; ядуусын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор үр ашигтай, ил тод зах зээлийн үйл ажиллагааг төрөөс дэмжинэ. Газрын дамын наймаа, газрыг төвлөрүүлэх болон газар эдэлбэрийн уламжлалт хэлбэрүүдийг урвуулан ашиглах зэргээр нутгийн иргэд, уугуул болон эмзэг бүлгийн хүмүүст тэдний хүсээгүй сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээг төрөөс авна. Төр болон бусад талууд зохицуулалтгүй зах зээлд нийгэм, соёл, байгаль орчны үнэт зүйлсийг төдийлэн хүндэтгэн үздэггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Төр нийгмийн өргөн хүрээний эрх ашгийг эдэлбэрийн зохистой бодлого, хуулиудаар дамжуулан хамгаална.
- 11.3 Ил тод, үр ашигтай зах зээлийн үйл ажиллагааг хангах, алагчлалгүй хүртээмжтэй байлгах, өрсөлдөөнт бус практикаас урьдчилан сэргийлэхийн тулд төрөөс бодлого, хууль, зохицуулалтын системүүдийг боловсруулж, агентлагуудыг үүсгэн байгуулна. Төрөөс ядуус болон нэн эмзэг бүлгийн хүмүүсийн зах зээлд оролцох боломжийг бууруулахгүйн тулд захиргааны журмуудаа хялбарчлах хэрэгтэй.
- 11.4 Төр болон бусад талууд хувийн нууцыг чандлан хадгалахын сацуу зах зээлийн арилжааны мэдээлэл болон зах зээлийн үнэлгээний мэдээлэл ил тод байж, нийтэд өргөнөөр сурталчлагдсан байх талаар анхаарна. Төр ийм төрлийн мэдээлэлд хяналт тавьж, зах зээлд сөрөг нөлөө үзүүлсэн, зах зээлийн өргөн хүрээний, эрх тэгш оролцоог бууруулсан тохиолдолд арга хэмжээ авна.
- 11.5 Төр эдэлбэрийн хамгаалалтыг нэмэгдүүлж, арилжааны зардал, эрсдэлийг бууруулах зорилгоор эдэлбэрийн эрх, үүргийн талаарх мэдээллийг хүртээмжтэй болгох газрын бүртгэл зэрэг зохих найдвартай бүртгэлийн системийг бий болгоно.
- 11.6 Газрын бүртгэл гэх мэт бүртгэлийн системд эдэлбэрийн эрх эзэмшигчээр бүртгэгдээгүй эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүд болон бусад хүмүүсийн хууль ёсны эдэлбэрийн эрхийг хамгаалах баталгааг төрөөс бий болгоно.
- 11.7 Төр болон төрийн бус оролцогчид зохих ёс зүйн стандартыг мөрдөж ажиллана. Тэд авилгаас сэргийлэх, ялангуяа нийтэд ил болгох замаар авилгаас сэргийлэх зорилгоор зах зээлийн үйл ажиллагаанд эдгээр стандартын хэрэгжилтийг олон нийтэд мэдээлж, хяналт тавина.

- 11.8 Үндэсний хэмжээний хүнсний аюулгүй байдал болон нийгмийн тогтвортой байдалд жижиг үйлдвэрлэгчид чухал ач холбогдолтой гэдэг үүднээс төр эдэлбэрийн арилжааны зах зээлийн үйл ажиллагааг дэмжихдээ жижиг үйлдвэрлэгчдийн эдэлбэрийн эрхийг хамгаална.

12. Хөрөнгө оруулалт

- 12.1 Төрийн болон төрийн бус оролцогчид хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад төрийн болон хувийн хэвшлийн хариуцлагатай хөрөнгө оруулалт чухал ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглал нь эдэлбэрийн эрх эзэмшигчдийн зүгээс эдгээр нөөцөд хариуцлагатай хөрөнгө оруулалт хийж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой өсгөж, орлого нэмэгдүүлэхийг хөхүүлэн дэмжих учиртай. Төрөөс аж ахуй эрхлэлтийн олон янзын системийн хүрээнд нийгэм, эдийн засаг, байгаль орчны илүү өргөн хэмжээний зорилтуудыг дэмжих газар, загас, ойн нөөцийн хариуцлагатай хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих хэрэгтэй. Бүх үйл ажиллагаа үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нийцэж байх учиртай.
- 12.2 Хөгжиж буй улс орнуудын жижиг үйлдвэрлэгчид болон тэдгээрийн байгууллагууд хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хангамж, ядуурлыг бууруулах, байгаль орчны нөхөн сэргээлтэнд чухал хувь нэмэр оруулдаг хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг гэдгийг харгалзан төрөөс жижиг үйлдвэрлэгчдийн хөрөнгө оруулалт, мөн түүнчлэн төрийн болон хувийн хэвшлийн жижиг үйлдвэрлэгчдийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгтэй.
- 12.3 Газар, загас, ойн нөөцөд хөрөнгө оруулсны үр дүнд хийгдэж буй эдэлбэрийн эрхийн бүх төрлийн арилжаа нь холбогдох үндэсний салбар дэмжсэн бодлогын хүрээнд ил тод байдлаар хийгдэх ба жижиг үйлдвэрлэгчдэд чиглэсэн нийгэм, эдийн засгийн өсөлт, тогтвортой хүний хөгжлийн зорилтуудтай нийцсэн байх учиртай.
- 12.4 Хариуцлагатай хөрөнгө оруулалт нь ямар ч хохирол учруулахгүй байх хийгээд зүй ёсны эдэлбэрийн эрх эзэмшигчдийн эрхийг шамшигдуулахаас хамгаалах, байгаль орчны хохирлоос сэргийлэх, хүний эрхийг хүндэтгэн үзэх ёстой. Ийм хөрөнгө оруулалт нь зохих шатны төрийн болон орон нутгийн газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрхийг эзэмшигчидтэй хамтран ажиллах, тэдний зүй ёсны эдэлбэрийн эрхийг хүндэтгэн үзэх үндсэн дээр хийгдэх ёстой. Хөрөнгө оруулалт нь ядуурлыг бууруулах; хүнсний аюулгүй байдал болон газар, ой, загасны нөөцийг тогтвортой ашиглах;

орон нутгийн иргэдийг дэмжих; хөдөөгийн хөгжилд хувь нэмэр оруулах; орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийн системийг дэмжин баталгаажуулах; нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах; ажлын байр бий болгох; амьжиргааны эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх; улс орондоо болон ард түмэндээ тухайлбал ядуу, нэн эмзэг бүлгийнхэнд ашиг шим хүртээх зэрэг бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд цаашдын хувь нэмэр оруулах учиртай хийгээд үндэсний хуулиуд, олон улсын хөдөлмөрийн үндсэн стандартууд мөн түүнчлэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлттэй уялдсан байх ёстой.

- 12.5 Төр зохих зөвлөгөөн, оролцооны тусламжтайгаар эдэлбэрийн эрхийн зөвшөөрөгдөх гүйлгээний хэмжээ, хамрах хүрээ, шинж чанарын талаар ил тод дүрэм журам гаргаж, үндэсний хэмжээнд эдэлбэрийн эрхийн том хэмжээний гүйлгээг тодорхойлно.
- 12.6 Төр эдэлбэрийн эрхийн том хэмжээний гүйлгээнээс үүсэж болзошгүй эрсдэлээс зүй ёсны эдэлбэрийн эрх, хүний эрх, амьжиргаа, хүнсний аюулгүй байдал болон байгаль орчныг хамгаалах баталгаа гаргана. Ийм баталгаанд арилжих газрын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох болон тодорхой хэмжээнээс хэтэрсэн арилжааг их хурлаар батлуулах гэх мэтийн зохицуулалтууд орж болно. Төрөөс эдэлбэрийн эрхийн томоохон хэмжээний шилжүүлэг хийхэд хүргэхээргүй үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын янз бүрийн загваруудыг хөрөнгө оруулагчдад санал болгох талаар авч үзэн, орон нутгийн эдэлбэрийн эрх эзэмшигчидтэй түншлэн ажиллахыг дэмжих нь зүйтэй.
- 12.7 Уугуул иргэд болон нутгийн бусад иргэдийн хувьд, төрөөс бүх үйл ажиллагааг үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, холбогдох бүсийн болон олон улсын баримт бичгээр сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтууд тухайлбал Тусгаар тогтносон улсуудын уугуул болон овог аймгийн иргэдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 169 дүгээр конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын уугуул иргэдийн эрхийг хамгаалах тухай тунхаглал зэрэгт нийцсэн байх талаар анхаарна. Төр болон бусад талууд нутгийн иргэдийн мэдэлд байгаа байгалийн нөөцөд нөлөөлөх аливаа хөрөнгө оруулалтын төслийг санаачлан эхлүүлэхээсээ өмнө уугуул иргэдтэй илэн далангүй зөвлөлдөх хэрэгтэй. Ийм төрлийн төслүүд энэхүү зөвлөмжийн 9.9 дүгээр зүйлд заасны дагуу уугуул иргэдтэй хийх үр дүнтэй, утга учир бүхий зөвлөгөөн дээр үндэслэсэн байна. Энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчмуудыг нутгийн бусад иргэдийн ашиглаж буй нөөцөд хамааралтай хөрөнгө оруулалт хийх үед баримтлана.
- 12.8 Төр энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчмын дагуу

нөлөөлөлд өртөж болох бүх талуудтай хамтран хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцлүүдийг тодорхойлох бөгөөд дараа нь хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжсэн, хүний эрхийг хүндэтгэсэн, хүнсний аюулгүй байдал болон байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжсэн бодлого, хуулиудыг боловсруулж, олон нийтэд таниулна. Хөрөнгө оруулалтын гэрээний бүх талуудын эрх, үүргийг ойлгомжтой тодорхойлох шаардлагыг хуульд тусгасан байна. Хөрөнгө оруулалтын гэрээ нь үндэсний эрх зүйн орчин, хөрөнгө оруулалтын тухай хуулиудтай нийцсэн байна.

- 12.9 Төрөөс эдэлбэрийн эрхийн бүх хэлбэрийн гүйлгээнд хамааралтай хөрөнгө оруулалт, тухайлбал худалдан авалт, түншлэлийн гэрээний заалтыг эдэлбэрийн эрх болон дагалдах эрхүүд нь хөндөгдөж болзошгүй талуудтай энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчмын дагуу хэлэлцэн боловсруулах ёстой. Төр болон бусад холбогдох талууд хувь хүн, гэр бүл, нутгийн иргэдэд эдэлбэрийн эрхийнх нь талаар мэдээлэл өгч, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн туслалцаа үзүүлэх зэргээр зөвлөгөө, оролцооны хэлбэрээр тэдний чадавхийг сайжруулахад тусална.
- 12.10 Эдэлбэрийн эрхийн том хэмжээний гүйлгээтэй холбоотой хөрөнгө оруулалт тухайлбал, худалдан авалт, түншлэлийн гэрээ хэлэлцэх үед төрөөс эдэлбэрийн эрх, хүнсний аюулгүй байдал, зохистой хүнсээр хангагдах эрхийн биелэлт, амьжиргаа, байгаль орчинд эдгээр хөрөнгө оруулалтын үзүүлж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөнд урьдчилсан, бие даасан үнэлгээ хийх талуудад тавигдах шаардлагын талаарх заалтуудыг боловсруулах хэрэгтэй. Уламжлалт ёсны болон албан бус эдэлбэр зэрэг хүчин төгөлдөр зүй ёсны эдэлбэрийн эрх болон нэхэмжлэлүүд, мөн түүнчлэн хөрөнгө оруулалтын нөлөөлөлд өртсөн жижиг үйлдвэрлэгчид зэрэг бусад хүмүүсийн эрх, амьжиргаа системтэйгээр, шударгаар тодорхойлогдсон байх тал дээр төрөөс анхаарах нь зүйтэй. Үүнийг энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчмын дагуу нөлөөлөлд өртсөн бүх талуудтай зөвлөлдөж хийнэ. Төр ийм төрлийн хөрөнгө оруулалтын улмаас хүчин төгөлдөр зүй ёсны эдэлбэрийн эрх зөрчигдөхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.
- 12.11 Гэрээний талуудын зүгээс хэлэлцээрт оролцож буй холбогдох бүх хүмүүс мэдээлэлтэй оролцох нөхцлийг бүрдүүлэн дэлгэрэнгүй мэдээллээр хангаж, гэрээ хэлэлцээрийг баримтжуулж, нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст ойлгуулсан байх тал дээр анхаарна. Хэлэлцээрийн үйл явц алагчлалгүй, жендерийн мэдрэмжтэй байна.
- 12.12 Энэхүү зөвлөмжийн төрийн бус оролцогч талуудад зориулсан ерөнхий зарчмын дагуу хөрөнгө оруулагчид үндэсний хууль тогтоомжийг хүндэтгэн, бусдын эдэлбэрийн эрх болон дүрэм, журмыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн дээдлэх хариуцлага хүлээнэ.

Хөрөнгө оруулалт нь хүнсний баталгаагүй байдал, байгаль орчны доройтолд хүргэх ёсгүй.

- 12.13 Төр, хөрөнгө оруулагчид болон газар, ой, загасны эдэлбэрийн эрхийг эзэмшигчдэд үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнүүд тусгайлан шаардлагатай эсэхээс үл хамааран үйлчилгээ үзүүлэхдээ бүх чадлаараа хичээнгүйлэн ажиллах шаардлагатай.
- 12.14 Төр болон нөлөөлөлд өртсөн талууд худалдан авалт, түншлэлийн гэрээ зэрэг эдэлбэрийн эрхийн том хэмжээний арилжаатай холбоотой гэрээний хэрэгжилт, нөлөөлөх байдалд үр дүнтэй хяналт-шинжилгээ хийхэд хувь нэмэр оруулна. Гэрээний хэрэгжилтийг хангах, эдэлбэрийн болон бусад эрхийг хамгаалах шаардлагатай тохиолдолд төрөөс залруулах арга хэмжээ авч, хохирогч талууд ийм арга хэмжээ авах хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох механизмыг бүрдүүлнэ.
- 12.15 Төрөөс гадаадад хөрөнгө оруулалт хийх эсхүл хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж байгаа тохиолдолд, төрийн үйл ажиллагаа нь зүй ёсны эдэлбэрийн эрхийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах болон үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байх тал дээр анхаарна.

13. Газрын нэгтгэл болон дахин зохион байгуулалтын арга замууд

- 13.1 Шаардлагатай тохиолдолд, хүнсний аюулгүй байдал, хөдөөгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах зэргээр өмчлөгчид, ашиглагчдад нэгж талбар болон эзэмшлийнхээ төлөвлөлт, ашиглалтыг сайжруулахад нь туслах зорилгоор төрөөс газрыг нэгтгэх, солилцоо хийх болон нэгж талбар, эзэмшлийг дахин зохион байгуулах сайн дурын арга замуудыг эрэлхийлнэ. Бүх үйл ажиллагаа үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байх талаар анхаарч, өөрчлөлтийн дараа өмнөхтэй харьцуулахад оролцогчдын байдал бага ч атугай сайжирсан байх нөхцөлийг бүрдүүлнэ. Эдгээр аргыг газар өмчлөгчид, ашиглагчдын сонголттой уялдуулан хуулийн зохицуулалтаар нэг удаа хэрэгжүүлнэ.
- 13.2 Зохистой тохиолдолд, төрөөс ашиг шим хүртэгсдэд газрын нэгж талбарыг хуваарилан олгох хүртэл тэдгээрийг түр хугацаанд мэдэлдээ аван эзэмших, газрын нөөцийг газар нэгтгэлийн хөтөлбөрийн нэг хэсэг болгон бий болгох асуудлыг хэлэлцэх боломжтой.
- 13.3 Зохистой тохиолдолд, төрөөс хувийн өмчийн газрыг байгаль

хамгаалах болон нийтийн хэрэгцээний зориулалттай дэд бүтцийн төслүүдийн хүрээнд аван газар нэгтгэл болон газрын нөөц бий болгох арга хэмжээ авч, нөлөөлөлд өртсөн өмчлөгчид, фермерүүд болон хүнсний жижиг үйлдвэрлэгчдэд нөхөн олговор хэлбэрээр өөр газар олгож, тэдэнд үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн цаашид илүү нэмэгдүүлэх боломж олгоно.

- 13.4 Жижиг гэр бүлийн эзэмшлийн фермүүд болон ойг олон нэгж талбаруудад хуваан зардал нэмэгдүүлж байгаа тохиолдолд, төрөөс тэдгээр фермийн болон ойн бүтцийг сайжруулахын тулд газрыг нэгтгэх, газрын сан байгуулах тухай асуудлыг хөндөн хэлэлцэж болно. Нэгж талбарт хуваах нь эрсдлийг бууруулах, таримлын нэр төрлийг олшруулах зэрэг үр өгөөжтэй байгаа тохиолдолд төр газар нэгтгэлээс татгалзах нь зүйтэй. Фермийг дахин төлөвлөхөд чиглэсэн газар нэгтгэлийн төслүүдийг усжуулалтын систем болон орон нутгийн замыг нөхөн сэргээх зэрэг фермерүүдийг дэмжих хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх хэрэгтэй. Нэгтгэсэн нэгж талбаруудыг цаашид хуваахыг хязгаарлаж, газар нэгтгэлийн хөрөнгө оруулалтыг хамгаалах арга хэмжээнүүдийг төлөвлөх шаардлагатай.
- 13.5 Төр тухайн орон нутгийн шаардлагад нийцсэн дахин зохион байгуулалтын стратегийг боловсруулна. Ийм стратегиуд нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой байдлыг хангасан, жендерийн мэдрэмжтэй байна. Стратегаар дахин зохион байгуулалтын зорилтууд болон зарчмуудыг тодорхойлно. Үүнд; ашиг шим хүртэгсэд; төрийн болон хувийн хэвшлийнхэн, фермерүүд, жижиг үйлдвэрлэгчид, загас болон ойн аж ахуй эрхлэгчдийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдын мэдлэг, чадавхийг сайжруулах асуудлууд багтана. Нэгж талбар болон эзэмшил, тэдгээрийн ашиглалтыг дахин төлөвлөх журмыг тодорхой, зардал хэмнэсэн байдлаар хуульд тусгана.
- 13.6 Төрөөс газар дахин зохион байгуулалтын төслүүдэд зохих ёсны баталгаануудыг тусгаж өгнө. Төслийн нөлөөнд өртөж болзошгүй хувь хүмүүс, нутгийн иргэд, бусад хүмүүстэй холбогдож, зохих ёсны хэлээр хангалттай мэдээлэл өгөх нь зүйтэй. Мэргэжлийн болон эрх зүйн дэмжлэг үзүүлнэ. Уугуул иргэдийн эрхийг харгалзан үзсэн оролцооны болон жендерийн мэдрэмжтэй арга замуудыг хэрэглэнэ. Газрын доройтол, биологийн төрөл зүйл устаж үгүй болохоос сэргийлж, эрсдэлийг багасгахад чиглэсэн байгаль хамгааллын баталгааг бий болгож, газрын сайн менежмент, тэргүүн туршлага, нөхөн сэргээх явдлыг урамшуулан дэмжинэ.

14. Эрх сэргээх

- 14.1 Зохистой тохиолдолд, төрөөс үндэсний онцлогтоо нийцүүлэн газар, ой, загасны нөөцийн зүй ёсны эдэлбэрийн эрх алдагдсан

тохиолдолд түүнийг сэргээх асуудлыг авч хэлэлцэнэ. Төрийн бүх үйл ажиллагаа үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байна.

- 14.2 Боломжтой тохиолдолд, анхны нэгж талбар болон эзэмшлийн эрхээ алдсан хохирогчид буюу тэдний өв залгамжлагчдад алдагдсан эрхийг нь үндэсний эрх мэдэл бүхий байгууллагуудын шийдвэрээр буцаан олгоно. Анхны нэгж талбар болон эзэмшлийг буцаан олгох боломжгүй тохиолдолд, төр нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст эрх тэгш хандах үүднээс, мөнгө болон/эсхүл өөр нэгж талбар болон эзэмшил хэлбэрээр зохих нөхөн олговрыг шуурхай олгоно.
- 14.3 Зохистой тохиолдолд, уугуул иргэдийн эрх сэргээх асуудлыг үндэсний онцлогийг харгалзан үндэсний хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 14.4 Төрөөс эрх сэргээх үйл явцын тодорхой, ил тод байдлыг хангасан, жендерийн мэдрэмжтэй бодлого, хуулиудыг боловсруулна. Эрх сэргээх дүрэм журмын талаарх мэдээллийг зохих ёсны хэлээр олон нийтэд түгээнэ. Бүхий л үйл явцын туршид эрх зүйн болон туслах эрх зүйн туслалцаа зэрэг зохих дэмжлэгийг нэхэмжлэгчдэд үзүүлэх хэрэгтэй. Төрөөс эрх сэргээх нэхэмжлэлийг түргэн, шуурхай шийдвэрлэх нь зүйтэй. Шаардлагатай тохиолдолд, эрхээ сэргээлгэсэн нэхэмжлэгчдэд эдэлбэрийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлнэ. Хэрэгжилтийн ахицын талаар олон нийтэд мэдээлж байх хэрэгтэй.

15. Дахин хуваарилалтын шинэчлэлүүд

- 15.1 Газрын нөөцийг өргөн хүрээнд, эрх тэгшээр хүртээмжтэй болгох, хөдөөгийн бүх талын хөгжлийг дэмжих зорилгоор дахин хуваарилалтын шинэчлэлийг хэрэгжүүлж болно. Энэ талаар төр үндэснийхээ онцлогт тохируулан зохистой тохиолдолд, төрийн мэдлийн газрыг олгох, сайн дурын болон зах зээлд суурилсан механизмуудыг бий болгох ба нийтийн хэрэгцээний зориулалтаар хувийн эзэмшлийн газар, загас, ойн нөөцөөс албадан нүүлгэх зэрэг арга хэмжээ авч болно.
- 15.2 Төрөөс дахин хуваарилалтын шинэчлэл явуулахдаа газрын дээд хэмжээг бодлогын асуудал болгон тогтооно.
- 15.3 Хувийн өмч хэт төвлөрч газар, ой, загасны нөөцийн хүртээмж муудсаны улмаас хөдөөгийн ядуурлын түвшин анхаарал татахуйц хэмжээнд хүрсэн зэрэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны шалтгаанаар, үндэсний онцлог болон үндэсний хууль тогтоомжийн дагуу дахин хуваарилалт хийж шинэчлэх асуудлыг авч үзэж болох

ба ингэхдээ, энэхүү зөвлөмжийн 15 дугаар зүйлд заагдсан бүх зүй ёсны эдэлбэр эзэмшигчдийн эрхүүдтэй нийцүүлэн авч үзнэ.

- 15.4 Төрөөс дахин хуваарилалтын шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ шинэчлэлүүд нь үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байна. Шинэчлэлийг хууль дүрмийг дээдлэн, үндэсний хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ. Төрөөс энэхүү зөвлөмжийн зарчмын дагуу бүх талын хэрэгцээний тэнцвэртэй байдлыг хангах зэрэг дахин хуваарилалтын талаар, мөн хэрэгжүүлэх арга замуудын талаар зөвлөлдөх үйл явцыг бий болгож, зохион байгуулна. Төр; нутгийн иргэд; иргэний нийгмийн байгууллагууд; хувийн хэвшил; фермерүүд, хүнсний жижиг үйлдвэрлэгчид, загас болон ойн аж ахуй эрхлэгчдийн байгууллагууд; болон бусад талуудын түншлэлийг хөгжүүлнэ. Ашиг шим хүртэгсдээс оруулах санхүүгийн болон бусад хандивыг тэднийг барагдашгүй өрийн дарамтад оруулахааргүй боломжийн хэмжээнд тогтоох хэрэгтэй. Газар, ой, загасны нөөцийн эдэлбэрийн эрхээ хураалгасан хүмүүст тэнцэх хэмжээний төлбөрийг ямар нэгэн саадгүй олгох ёстой.
- 15.5 Төрөөс дахин хуваарилалтын шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ, шинэчлэлийн хөтөлбөрийн зорилтуудыг нарийвчлан тодорхойлж, дахин хуваарилалтанд хамрагдахгүй газрыг зааж өгнө. Эрхийн ногооны талбайтай болохыг зорьж байгаа хүмүүс, айл өрхүүд, эмэгтэйчүүд, албан бус суурьшмал иргэд, малчид, түүхийн явцад хохирсон бүлгүүд, нийгмээс тусгаарлагдсан бүлгүүд, залуучууд, уугуул иргэд, ургац хураагчид болон хүнсний жижиг үйлдвэрлэгчид зэрэг зорилтот үр шим хүртэгсдийг нарийн тодорхойлсон байна.
- 15.6 Төрөөс дахин хуваарилалтын шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ тогтвортой байдлыг хангах үүднээс бодлого, хуулиудыг оролцооны үйл явцаар дамжуулан боловсруулна. Төрөөс нутгийн иргэд, хувь хүмүүс, айл өрхүүд зэрэг зорилтот ашиг шим хүртэгсэд олж авсан газар, ой, загасны нөөцөөрөө амьдралынхаа түвшинг зохих ёсоор сайжруулахад нь туслах бодлого хуулиар дэмжиж, дахин хуваарилалтын шинэчлэлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлаар тусгагдсан байхад анхаарна. Төрөөс дахин хуваарилалтын шинэчлэлийн зорилтууд амжилттай хэрэгжиж тогтвортой үр дүнтэй байхад саад болж буй бодлогуудыг дахин хянах шаардлагатай.
- 15.7 Дахин хуваарилалтын шинэчлэлийг хэлэлцэх явцад төр, шаардлагатай хэмээн үзвээс, тэдгээр шинэчлэлийн эдэлбэрийн эрх, хүнсний аюулгүй байдал болон зохистой хүнсээр хангагдах эрхийн баталгаа, амьжиргаа, байгаль орчинд үзүүлэх боломжит эерэг болон сөрөг нөлөөлөлд үнэлгээ хийлгэж болно. Үнэлгээний үйл явцыг энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчимд

нийцүүлэн явуулна. Үнэлгээний үр дүнг ашиг шим хүртэгсдийг дэмжих, дахин хуваарилалтын хөтөлбөрийг сайжруулах шаардлагатай арга хэмжээг тодорхойлоход үндэслэл болгон ашиглаж болно.

- 15.8 Төр газар дахин хуваарилалтын шинэчлэлийн хөтөлбөрт ашиг шим хүртэгсдэд зээл, ургацын даатгал, түүхий эд, зах зээлийг хүртээмжтэй болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, фермийн аж ахуйг хөгжүүлэх, орон сууцтай болоход нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх зэрэг дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг тусгасан байхад анхаарна. Дэмжлэг үзүүлэх үйлчилгээг ашиг шим хүртэгсдийн газар дээрх хөдөлгөөнтэй уялдуулан зохицуулна. Дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зардал гэх мэт газрын шинэчлэлийн нийт зардлыг урьдчилан тооцоолж, холбогдох төсөвт тусгасан байна.
- 15.9 Төр дахин хуваарилалтын шинэчлэлийг ил тод, оролцоотой, хариуцлагатай байхарга зам, дүрэм журмыг баримтлан хэрэгжүүлнэ. Нөлөөлөлд өртсөн бүх талууд үндэсний хууль тогтоомж болон 16 дугаар зүйлд тусгагдсан заалтын дагуу зохих ёсны үйл явцад оролцож, зохих нөхөн олговрыг авах ёстой. Нөлөөлөлд өртсөн бүх талууд түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн иргэд шинэчлэлийн талаар бүрэн, тодорхой мэдээллийг тухайлбал жендерийн зорилтот бүлэгт хандсан мессэжээр дамжуулан авах ёстой. Ашиг шим хүртэгсдийг нээлттэй байдлаар сонгох бөгөөд тэдэнд улсын бүртгэлтэй, баталгаатай эдэлбэрийн эрх олгоно. Үндэсний хуулийн дагуу маргаан шийдвэрлэх арга хэрэгслээр хангана. Дахин хуваарилалтын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ил тод байдал, оролцоог нэмэгдүүлэх замаар авилгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс авна.
- 15.10 Төр холбогдох бусад талуудын оролцоотойгоор дахин хуваарилалтын шинэчлэлийн хөтөлбөрийн үр дүн түүний дотор 15.8 дугаар зүйлд заасан дагалдах бодлогуудын үр дүн, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль альных нь газрын хүртээмж, хүнсний аюулгүй байдалд тэдгээрийн үзүүлсэн нөлөөлөлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж шаардлагатай тохиолдолд, төрөөс сайжруулах арга хэмжээ авна.

16. Эрх цуцлах ба нөхөн олговор

- 16.1 Үндэсний хууль тогтоомжийн дагуу болон үндэсний нөхцөл байдалтай уялдуулан, төр зөвхөн нийтийн хэрэгцээний зориулалтад шаардлагатай газар, ой, загасны эдэлбэрийн эрхийг цуцлана. Төр шүүхээс хянах нөхцлийг бүрдүүлэхийн тулд нийтийн хэрэгцээний зориулалт гэсэн ойлголтыг хуулиар нарийн тодорхойлсон байна. Бүх үйл ажиллагаа үндэсний хуулийн дагуу явагдаж, үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн

хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байна. Төр зүй ёсны эдэлбэрийн эрх эзэмшигчдийн ялангуяа эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан бүлгийн хүмүүсийн эрхийг хүндэтгэх ёстой бөгөөд зайлшгүй хэрэгцээний хамгийн бага хэмжээтэй нөөцийг татан авч, үндэсний хууль тогтоомжийн дагуу зохих нөхөн олговрыг шуурхай олгоно.

- 16.2 Эрх цуцлалтын төлөвлөлт болон үйл явц, ил тод, оролцоотой байх тал дээр төрөөс анхаарна. Нөлөөлөлд өртөх магадлалтай хүн бүрийг тодорхойлж, зохих ёсны мэдээллээр хангаж, бүх шатанд зөвлөлдөнө. Зөвлөгөөнөөр, энэхүү зөвлөмжийн зарчмуудын дагуу нийтийн зориулалтаар нөөц бий болгох бусад боломжит аргуудтай холбоотой мэдээллийг өгөх бөгөөд амьжиргаанд хамгийн бага нөлөөлөх стратегиудыг хэлэлцэнэ. Төр эрх цуцлах төлөвлөгөөт газар нь соёл, шашин, байгаль орчны онцгой чухал ач холбогдолтой эсэх, хэлэлцэгдэж буй газар, ой, загасны нөөц газрууд нь ядуу болон эмзэг бүлгийн хүмүүсийн амьжиргаанд онц чухал ач холбогдолтой эсэхэд мэдрэмжтэй хандах шаардлагатай.
- 16.3 Төр үндэсний хуулийн дагуу шударга үнэлгээ хийж, нөхөн олговрыг цаг тухайд нь олгоно. Нөхөн олговор нь бусад хэлбэрээс гадна жишээ нь бэлэн мөнгө, өөр газрын эрх эсхүл эдгээрийг хослуулсан зэрэг хэлбэрээр байж болно.
- 16.4 Төр нөөц бололцооныхоо хэрээр хэрэгжүүлэгч агентлагуудын хүн хүч, хөрөнгө, санхүү болон бусад төрлийн чадавхийг бүрдүүлэх тал дээр анхаарна.
- 16.5 Төлөвлөгөөний өөрчлөлтийн улмаас газар, ой, загасны нөөц шаардлагагүй болсон тохиолдолд төр хамгийн түрүүнд анхдагч эрх эзэмшигчдэд эдгээр нөөцийг буцаан авах боломжийг олгоно. Энэ тохиолдолд эрхийг буцаан олгохдоо эрх цуцлахад төлсөн нөхөн олговрын хэмжээг харгалзан үзэх нь зүйтэй.
- 16.6 Бүх талууд бодитоор хийсэн үнэлгээ, ил тод ба төвлөрсөн бус үйл явц, болон үйлчилгээ, давж заалдах эрх зэрэг аргаар дамжуулан авилгаас урьдчилан сэргийлэхийг хичээн ажиллах нь зүйтэй.
- 16.7 Газар, ой, загасны эдэлбэрийн эрхийг нийтийн хэрэгцээний зориулалтаар цуцалж нүүлгэн шилжүүлж буй тохиолдолд төр хүний эрхийг хүндэтгэн, хамгаалах болон хэрэгжүүлэх талаар хүлээсэн холбогдох хариуцлагын дагуу нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулж, нөлөөлөлд өртсөн талуудтай хүндэтгэлтэй харьцана.
- 16.8 Төрөөс хувь хүмүүс, нутгийн иргэдийг үржил шимтэй нөөц хүртэх боломжоос нь салгаж болзошгүй нүүлгэн шилжүүлэлт хийх болон газар ашиглалтын зориулалтыг нь өөрчлөхөөс өмнө энэхүү

зөвлөмжийн зарчмын дагуу мөн түүнчлэн нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх, нүүлгэн шилжүүлэхээс өөр аргагүйд хүрсэн шаардлагыг ядаж багасгах арга зам хайх үүднээс нөлөөлөлд өртөх талуудтай зөвлөлдөж өөр боломжит хувилбаруудыг судална.

- 16.9 Нүүлгэн шилжүүлэх, дахин байршуулах нь хүний эрхийг зөрчиж хувь хүмүүсийг орон гэргүй болгож, эмзэг байдалд оруулахааргүй байх хэрэгтэй. Нөлөөлөлд өртсөн хүмүүс өөрсдөө асуудлаа шийдвэрлэх боломжгүй тохиолдолд төрөөс нөөц бололцооныхоо хэрээр шаардлага хангасан орон байраар хангах, нүүлгэн суурьшуулах, эсхүл үржил шимтэй газар, ой, загасны нөөцөөр хангах зэрэг боломжийн арга хэмжээ авна.

Эдэлбэрийн удирдлага

Энэ бүлэгт эдэлбэрийн эрхийн бүртгэл, үнэлгээ, татвар, зохицуулалттай орон зайн төлөвлөлт, эдэлбэртэй холбоотой маргаан шийдвэрлэлт, хил дамнасан асуудлуудтай холбоотой газар, ой, загасны нөөцийн эдэлбэрийн удирдлага, засаглалын тухай авч үзнэ.

17. Эдэлбэрийн эрхийн бүртгэл

- 17.1 Төрөөс эдэлбэрийн эрхийн баталгаа тухайлбал, төр, төрийн болон хувийн хэвшил, уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад нутгийн иргэдийн эзэмшиж буй эдэлбэрийн эрхийн баталгааг сайжруулах зорилгоор, мөн орон нутгийн нийгмийн амьдрал, зах зээлийн үйл ажиллагаанд зориулан хувийн болон хамтын эдэлбэрийн эрхийг бүртгэх (бүртгэл, кадастр, зөвшөөрлийн систем гэх мэт) систем бүрэлдүүлнэ. Ийм системд эдэлбэрийн эрх, үүрэг, тэдгээрийг эзэмшиж буй хүмүүсийн талаарх мэдээллийг бүртгэж, боловсруулж, олон нийтэд мэдээлэх хийгээд тухайн эрх үүргүүд нь газар, ой, загасны нөөцийн ямар нэгж талбарууд, эзэмшилд хамааралтай болох талаарх мэдээллийг олон нийтэд зориулсан мэдээлэлд багтаасан байна.
- 17.2 Төрөөс хүний нөөцийн болон санхүүгийн боломжиндоо тулгуурлан үндэсний онцгой нөхцөл байдалд тохирсон бүртгэлийн системийг бий болгоно. Уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эрхийг бүртгэх нийгэм, соёлын зохистой аргыг боловсруулж ашиглана. Төрөөс орон зайн төлөвлөлтөнд зориулагдсан, мэдээллийн бусад эх үүсвэрүүдэд нээлттэй,

тэдэнтэй нийцтэй байх явдлыг сайжруулах болон бусад зорилгоор хүчин төгөлдөр байгаа бүртгэлийн систем болон бусад орон зайн мэдээллийн системүүдийг нэгтгэсэн нэг тогтолцоо бий болгохыг эрмэлзэх нь зүйтэй. Аливаа шүүх эрх мэдлийн байгууллагад төр болон төрийн, хувийн хэвшлийн, уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн эрхийн бүртгэлийг нэгдсэн бүртгэлийн системд байршуулна. Уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн эдэлбэрийн эрх болон албан бус суурьшлыг бүртгэх боломжгүй тохиолдолд тухайн газрын эрхийг өрсөн бүртгүүлэхээс зайлсхийхэд онцгой анхаарах хэрэгтэй.

- 17.3 Төрөөс хүн бүр эдэлбэрийн эрхээ бүртгүүлэх боломжтой байж, ямар ч үндэслэлээр алагчлагдалгүй мэдээлэл олж авах боломжтой байх тал дээр анхаарна. Зохистой тохиолдолд, газрын бүртгэлийн алба зэрэг хэрэгжүүлэгч агентлагууд эмэгтэйчүүд, ядуучууд, эмзэг бүлгийн хүмүүст хүртээмжтэй байх талыг нь харгалзан үйлчилгээний төв эсхүл хөдөлгөөнт алба зэргийг байгуулах хэрэгтэй. Төр эдэлбэрийн эрхтэй холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор хуульч, нотариатч, газар хуваарилан зохиогч, нийгэм судлаач зэрэг орон нутгийн мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах талаар бодолцох хэрэгтэй.
- 17.4 Хэрэгжүүлэгч агентлагууд үйлчилгээний зардал, хугацаа хэмнэх зорилгоор хялбаршуулсан журам гаргаж, орон нутагт тохирсон технологийг ашиглана. Нэгж талбарын орон зайн нарийвчлал болон бусад орон зайн нэгжүүд орон нутгийн хэрэгцээг тодорхойлоход хангалттай байх шаардлагатай бөгөөд цаашид шаардлагатай тохиолдолд орон зайн нарийвчлалыг улам сайжруулна. Эдэлбэрийн эрхийн бүртгэлийн ашиглалтыг сайжруулахын тулд хэрэгжүүлэгч агентлагууд эдэлбэрийн эрхүүд, тэдгээр эрхийг эзэмшигчид, тэдгээр эрхэд хамааралтай орон зайн нэгжүүдийн тухай мэдээллийг хооронд нь уялдаатай болгох шаардлагатай. Өрсөлдөөнтэй болон давхардсан эрхүүдийг тодорхойлохын тулд бүртгэлийг орон зайн нэгжүүд болон эрх эзэмшигчдээр индексжүүлэх нь зүйтэй. Олон нийтийг мэдээлэлтэй байлгах өргөн цар хүрээний ажлын хүрээнд үйлчилгээг сайжруулах үүднээс эдэлбэрийн эрхийн бүртгэлийг төрийн агентлагууд, орон нутгийн захиргаадад нээлттэй болгох нь зүйтэй. Мэдээллийг үндэсний стандартуудын дагуу эдэлбэрийн эрхийг нарийвчлан ангилсан мэдээллийн хамт олгоно.
- 17.5 Төр хувийн нууцыг хамгаалахын сацуу эдэлбэрийн эрхийн талаарх мэдээллийг бүх нийтэд хялбар хүртээмжтэй байлгана. Хувийн нууцыг хамгаалах хязгаарлал нь авилга болон хууль бус арилжааг илрүүлэх зорилготой олон нийтийн хараа хяналт тавих ажилд үндэслэлгүйгээр саад учруулах ёсгүй. Төр болон төрийн

бус оролцогч талууд үйл явц, тавигдах шаардлагууд, төлбөр, төлбөрийн хөнгөлөлт, үйлчилгээний хүсэлтэд хариу өгөх эцсийн хугацаа зэргийг олон нийтэд мэдээлэх замаар эдэлбэрийн эрхийг бүртгэх явцад авилга гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй.

18. Үнэлгээ

- 18.1 Төр хөрөнгө оруулалт, эрх цуцлах болон татвар ногдуулалтын хүрээнд бий болсон зах зээлийн үйл ажиллагаа, зээлийн баталгаа, эдэлбэрийн эрхийн арилжаа зэрэг тусгай зориулалтын эдэлбэрийн эрхийн үнэлгээг шударга байдлаар цаг тухайд нь хийх зохистой системүүдийг бий болгох талаар анхаарна. Эдгээр систем нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин, тогтвортой хөгжлийн өргөн хүрээний зорилтуудыг дэмжихэд чиглэгдэнэ.
- 18.2 Үнэлгээтэй холбоотой бодлого, хуулиудыг боловсруулахдаа үнэлгээний системд нийцэх тохиолдолд, нийгэм, соёл, шашин, оюун санааны болон байгаль орчны зэрэг зах зээлийн бус үнэт зүйлсийг тусгасан байх тал дээр анхаарах нь зүйтэй.
- 18.3 Төр эдэлбэрийн эрхийн үнэлгээ хийхэд ил тод байдлыг хангахыг дэмжсэн мөн шаардсан бодлого, хуулиудыг боловсруулна. Үнэт зүйлсийн үнэлгээг үнэн зөв, найдвартай хийх үндэслэл болгох зорилгоор худалдах үнэ болон бусад холбогдох мэдээллийг бүртгэн дүн шинжилгээ хийж хүртээмжтэй болгоно.
- 18.4 Төр болон бусад талууд төрийн, арилжааны болон бусад зориулалтаар үнэлгээ хийх үндэсний стандартуудыг боловсруулж, нийтлэнэ. Үндэсний стандартууд нь холбогдох олон улсын стандартуудтай нийцсэн байна. Ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрт аргачлал болон олон улсын стандартуудын талаар тусгана.
- 18.5 Хэрэгжүүлэгч агентлагууд үндэсний стандартуудын дагуу өөрсдийн үнэлгээний мэдээлэл болон дүн шинжилгээг нийтэд ил тод байлгана. Төрөөс мэдээллийн болон аргачлалын ил тод байдлаар дамжуулан үнэлгээний явцад гарч болзошгүй авилга, мөн төрийн нөөцийн захиран зарцуулалт болон нөхөн олговор, компаний данс хөтлөлт, зээлжилтийн явцад гарч болзошгүй авилгаас сэргийлэхийг эрмэлзэнэ.

19. Татвар ногдуулалт

- 19.1 Төр нийгэм, эдийн засаг, байгаль орчны томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд түлхэц болох зорилгоор эдэлбэрийн эрхтэй холбоотой татвараар дамжуулан орлого нэмэгдүүлэх эрх эдэлнэ. Эдгээр зорилтонд хөрөнгө оруулалтыг дэмжих, өмчлөх болон бусад эдэлбэрийн эрхийн дамын наймаа болон төвлөрөл

зэргээс үүсч болох зохисгүй үр дагавраас урьдчилан сэргийлэх зэрэг зүйлс багтаж болно. Татвар нь арилжааг бүртгүүлэх болон борлуулалтынхаа нийт үнийг мэдүүлэх зэрэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны хүрээний таатай үйлдлүүдийг дэмжих ёстой.

- 19.2 Төр эдэлбэрийн эрхийн татвартай холбоотой бүх асуудлыг зохицуулах бодлого, хуулиуд, болон зохион байгуулалтын бүтэц бий болгохыг хичээх хэрэгтэй. Зохистой тохиолдолд, татварын бодлого, хуулиуд нь засгийн газрын нэгжүүдийг үр ашигтай санхүүжүүлэх, орон нутгийг үйлчилгээ болон дэд бүтцээр хангахад чиглэгдсэн байна.
- 19.3 Төр татварыг үр ашигтай, ил тод байдлаар захиран зарцуулна. Хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтнуудыг аргачлалыг тусгасан сургалтанд хамруулна. Татвар нь бодит үнэлгээнд үндэслэсэн байна. Үнэлгээний тооцоо болон татвар ногдуулах хэмжээг нийтэд нээлттэй мэдээлнэ. Төрөөс татвар төлөгчид үнэлгээний тухай гомдол гаргах эрх олгоно. Төрөөс бодит үнэлгээний хэрэглээнд ил тод байдлыг сайжруулах замаар татварын зохицуулалтанд гарч болзошгүй авилгаас сэргийлэхийг эрмэлзэнэ.

20. Зохицуулалттай орон зайн төлөвлөлт

- 20.1 Зохицуулалттай орон зайн төлөвлөлт нь хуулийн хүрээнд ашиглалтыг хязгаарлан эдэлбэрийн эрхэд нөлөөлж байдаг. Төрөөс зохицуулалттай орон зайн төлөвлөлт түүний дотор газар нутгийн тэнцвэртэй болон тогтвортой хөгжлийн төлөвлөлтийг хийж, энэхүү зөвлөмжийн зорилтуудыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан төлөвлөгөөнд хяналт шинжилгээ хийж хэрэгжилтийг хангана. Энэ утгаараа газар, загас, ойн нөөц ашиглалтын олон төрлийн зорилтуудыг орон зайн төлөвлөлтөнд уялдуулан нийцүүлэх нь зүйтэй.
- 20.2 Төрөөс зохицуулалттай орон зайн төлөвлөлтийн талаарх жендерийн мэдрэмжтэй бодлого, хуулиудыг зөвлөгөөн ба оролцооны аргаар боловсруулж, нийтэд мэдээлнэ. Зохистой тохиолдолд албан ёсны төлөвлөлтийн системд уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэдийн төлөвлөлт, газар нутгийн хөгжлийн аргууд болон тэдгээр нутгийн иргэдийн шийдвэр гаргах үйл явцыг харгалзаж үзнэ.
- 20.3 Төрөөс зохицуулалттай орон зайн төлөвлөлтөнд газар, загас, ойн нөөц, тэдгээрийн ашиглалтын харилцан уялдаатай харилцаа, нөөц ашиглалтын жендерийн асуудал зэргийг харгалзан үзэж тусгах нь зүйтэй. Төрийн, нутгийн иргэдийн болон хувийн сонирхлыг харилцан уялдуулж, тэргүүлэх зэргээр нь эрэмбэлэн олон төрлийн ашиглалтын шаардлага тухайлбал хөдөөгийн иргэдийн, хөдөө аж ахуйн, нүүдлийн, хотын иргэдийн, байгаль орчны зэрэг ашиг сонирхолтой уялдуулан зохицуулах нь зүйтэй.

Орон зайн төлөвлөлтөнд давхардсан болон хугацаат эрх зэрэг эдэлбэрийн бүх хэлбэрийн эрхийг харгалзан үзсэн байна. Орон зайн төлөвлөлтийн зохих эрсдлийн үнэлгээг хийлгэсэн байх шаардлагатай. Үндэсний, бүсийн болон орон нутгийн орон зайн төлөвлөгөөнүүд хоорондоо уялдаатай байх ёстой.

- 20.4 Төрөөс уугуул иргэд болон хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид зэрэг нутгийн иргэдийн тэргүүлэх асуудлууд, сонирхлыг тусгахын тулд төлөвлөлтийн төсөл боловсруулах, орон зайн төлөвлөгөөний төслийг хэлэлцэхэд олон нийтийг өргөнөөр оролцуулахад анхаарна. Шаардлагатай тохиолдолд төлөвлөлтийн явцад нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлнэ. Хэрэгжүүлэгч агентлагууд оролцооны үеэр гарсан олон нийтийн саналууд орон зайн төлөвлөгөөний эцсийн хувилбарт хэрхэн тусгагдсаныг олон нийтэд ил тод болгоно. Төр орон зайн төлөвлөлт хийх эрх мэдлийг, тухайлбал, зохицуулалттай ашиглалтын өөрчлөлтүүдтэй холбоотойгоор эрх мэдлийг буруугаар ашиглахаас хамгаалах баталгаа бий болгож, авилгаас сэргийлэхийг эрмэлзэнэ. Хэрэгжүүлэгч агентлагууд биелэлтийн хяналт-шинжилгээний үр дүнг мэдээлнэ.
- 20.5 Орон зайн төлөвлөлтөөр газар, ой, загасны нөөцийн төрөлжсөн, тогтвортой, тухайлбал агро-экологийн аргууд, тогтвортой эрчимжүүлэлт, уур амьсгалын өөрчлөлт болон хүнсний аюулгүй байдлын сорилтуудыг даван туулах асуудлуудыг багтаасан менежментийг хөгжүүлэхэд онцгой анхаарвал зохино.

21. Эдэлбэрийн эрхтэй холбоотой маргаан шийдвэрлэлт

- 21.1 Төрөөс шударга, нэр хүндтэй шүүх, захиргааны байгууллагуудаар дамжуулан эдэлбэрийн эрхтэй холбоотой маргааныг шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй аргаар тухайлбал ийм төрлийн маргааныг шийдвэрлэх бусад аргуудыг ашиглах боломж олгож, үр дүнтэй залруулах аргуудыг хэрэглэж давж заалдах эрхээр хангана, Гарсан шийдвэрийн хэрэгжилтийг нэн даруй хангана. Төрөөс бүх хүнийг болзошгүй маргаанаас зайлсхийх эсхүл маргааныг эхний шатанд нь шийдвэрлэх эс бөгөөс хэрэгжүүлэгч агентлагийн хүрээнд болон гадны байгууллагын тусламжтайгаар шийдвэрлүүлэх механизмаар хангана. Маргаан шийдвэрлэх үйлчилгээ нь бүх хүмүүст, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд байршил, хэл, дүрэм журмын хүрээнд хүртээмжтэй байх ёстой.
- 21.2 Төрөөс тусгай шүүх эсхүл зөвхөн эдэлбэрийн эрхтэй холбоотой маргаан хариуцсан мэргэшсэн шүүх байгуулах, шүүх байгууллагуудад мэргэжлийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоо бий болгох талаар авч үзнэ. Мөн төрөөс зохицуулалттай орон зайн төлөвлөлт, судалгаа, үнэлгээтэй холбоотой маргаан хариуцсан тусгай шүүхийг үүсгэн байгуулах талаар анхаарч үзнэ.
- 21.3 Төрөөс ялангуяа орон нутгийн түвшинд маргаан шийдвэрлэх бусад

хэлбэрийг бэхжүүлж хөгжүүлнэ. Маргаан шийдвэрлэх уламжлалт ёсны болон бусад тогтсон хэлбэрүүд байгаа тохиолдолд тэдгээрийг эдэлбэрийн маргааныг шударга, найдвартай, хүртээмжтэй болон алагчлалгүй хэлбэрээр, зохих ёсоор шийдвэрлэхэд ашиглана.

- 21.4 Төрөөс үндэсний хэмжээнд маргаан шийдвэрлэхдээ хэрэгжүүлэгч агентлагуудыг тэдний мэрэгшлийн хүрээнд тухайлбал хувь хүмүүсийн нэгж талбарын хоорондын хил заагийн маргаантай асуудлыг шийдвэрлэх судалгааны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн тусламжтайгаар асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлнэ. Шийдвэрийг бичгээр, бодит үндэслэлтэйгээр үйлдэн хүргэх бөгөөд шүүх байгууллагуудад хандан давж заалдах эрхээр хангах хэрэгтэй.
- 21.5 Төрөөс маргаан шийдвэрлэх үйл явцад гарч болзошгүй авилгаас сэргийлэх арга хэмжээ авна.
- 21.6 Төрөөс маргаан шийдвэрлэх арга механизмаар хангахдаа эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан хүмүүст эрх зүйн туслалцаа үзүүлж, бүх нийтийг алагчлалгүй шүүхэд хандах найдвартай эрхээр хангана. Шүүх болон бусад холбогдох байгууллагууд ажилтнууддаа тухайн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай чадвар, чадавхийг эзэмшин, хөгжихөд нь туслах үүрэгтэй.

22. Хил дамнасан асуудал

- 22.1 Улс орнууд үндэсний хил дамнасан газар, ой, загасны нөөцийн эдэлбэртэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ зохих механизмын дагуу болон нөлөөлөлд өртсөн талуудыг оролцуулан хамтран ажиллах шаардлагатай. Бүх үйл ажиллагаа үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцсэн байна. Эдэлбэрийн эрхтэй холбоотой хил дамнасан асуудал үүссэн улс орнуудад, талууд шилжин суурьшиж байгаа иргэд тухайн холбогдох газар нутагт амьдарч байгаа үед нь тэдний эдэлбэрийн эрх, амьжиргаа болон хүнсний аюулгүй байдлыг хамгаалах тал дээр хамтран ажиллах нь зүйтэй.
- 22.2 Улс орнууд болон бусад талууд олон улсын хил дамнасан бэлчээр болон нүүдэлчин малчдын улирлын шинж чанартай бэлчээр нутаг, жижиг загасны аж ахуйн загасчлах талбай зэрэг нутгийн иргэдэд нөлөөтэй хил дамнасан эдэлбэрийн асуудлуудын тухай харилцан ойлголцож, хамтран ажиллана.
- 22.3 Зохистой тохиолдолд улс орнууд эдэлбэрийн засаглалын эрх зүйн стандартуудыг үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтайгаа

уялдуулан нийцүүлнэ. Зохистой тохиолдолд энэхүү үйл ажиллагааг холбогдох бүсийн байгууллагууд болон нөлөөлөлд өртсөн талуудтай харилцан уялдаа холбоотойгоор явуулна. Улс орнууд нь нөлөөлөлд өртсөн талуудын оролцоотойгоор олон улсын хил дамнасан эдэлбэрийн эрхүүдийг зохицуулах хүчин төгөлдөр олон улсын арга хэмжээг хөгжүүлэн сайжруулна. Зохистой тохиолдолд холбогдох бүсийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллана. Үүнийг 4.8 дугаар зүйлд заасны дагуу нөлөөлөлд өртөх бүх талуудын эрх, ялангуяа амьжиргааг нь хамгаалахын тулд хийх хэрэгтэй.

Уур амьсгалын өөрчлөлт болон онцгой байдлын үед авах арга хэмжээ

Энэ бүлэг нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, зөрчилдөөний нөхцөл байдлын үеийн газар, загас, ойн эдэлбэрийн засаглалын тухай болно.

23. Уур амьсгалын өөрчлөлт

- 23.1 Төрөөс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс сэргийлж, хариу арга хэмжээ авах зорилгоор хүлээсэн холбогдох үүрэг, тухайлбал уур амьсгалын өөрчлөлтийн хамрах хүрээний тухай гэрээний нөхцлүүдийн дагуу бүх хүмүүс, нутгийн иргэд болон нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүс, ялангуяа фермерүүд, хүнсний жижиг үйлдвэрлэгчид, эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан бүлгийн иргэдийн газар, загас, ойн зүй ёсны эдэлбэрийн эрхийг хүндэтгэж, бодлого, хууль, стратеги, үйл ажиллагааны хүрээнд хамгаална.
- 23.2 Шаардлагатай тохиолдолд, магадгүй уур амьсгалын өөрчлөлтийн улмаас шилжин суурьшсан бүх хүмүүс, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй зөвлөлдөн тэдний оролцоотойгоор стратеги, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг төрөөс эрмэлзэнэ. Шилжин суурьшсан иргэдийн газар, загас, ой нөөц болон амьжиргааны аливаа хангамжийн асуудал нь бусдын

амьжиргааг эрсдэлд оруулахааргүй байх ёстой. Мөн төрөөс жижиг арлын болон бусад хөгжиж буй улс орнуудад онцгой туслалцаа үзүүлэх талаар анхаарна.

- 23.3 Төрөөс энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчмын дагуу дасан зохицох хөтөлбөрүүдийн талаар хэлэлцэж, хэрэгжүүлэхдээ зүй ёсны эдэлбэрийн эрх эзэмшдэг бүх хүмүүс, нутгийн иргэд болон бусад хүмүүс, ялангуяа фермерүүд, хүнсний жижиг үйлдвэрлэгчид, эмзэг болон нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн оролцоог хангах нь зүйтэй.

24. Байгалийн гамшиг

- 24.1 Бүх талууд байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, онцгой байдлын арга хэмжээ авахдаа газар, загас, ойн эдэлбэрийн эрхийн асуудлыг анхаарч үзнэ. Орон зайн төлөвлөлт зэрэг эдэлбэрийн эрхийн зохицуулалтын төлөвлөгөөнд байгалийн гамшгийн болзошгүй үр дагавраас урьдчилан сэргийлэх болон түүнийг бууруулах арга хэмжээг тусгаж өгнө.
- 24.2 Бүх үйл ажиллагаа үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нь нийцсэн байна. Бүх талууд холбогдох олон улсын зарчмуудыг тухайлбал, Дүрвэгсэд ба шилжин суурьшсан хүмүүсийн орон сууц, эд хөрөнгийн эрхийг сэргээх тухай НҮБ-ын зарчим ("Пинхерогийн Зарчим"), Гамшгийн үеийн арга хэмжээнд баримтлах хүмүүнлэгийн дүрэм ба минимум стандартууд зэргийг баримтлан ажиллана.
- 24.3 Төрөөс гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах хөтөлбөрүүдэд эдэлбэрийн асуудлыг тусгасан байна. Нөлөөлөлд өртөж болзошгүй газруудад зүй ёсны эдэлбэрийн эрхийн тухай мэдээллийг энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчмын дагуу цуглуулна. Байгалийн гамшгийн тохиолдолд зүй ёсны эдэлбэрийн эрхийн бүртгэлийн систем уян хатан үйлчлэх бөгөөд тухайлбал, эдэлбэрийн эрх эзэмшигчдэд эрхээ нотолж, өөрсдийн нэгж талбар болон бусад орон зайн нэгжүүдийг дахин байршуулах боломж олгох үүднээс бүртгэлийн мэдээллийг өөр газар байршуулж болно. Төрөөс байгалийн гамшгийн үед хүмүүсийг түр хугацаагаар нүүлгэн суурьшуулах боломжтой газруудыг тодорхойлж, тухайн орон нутагт эдэлбэрийн баталгааг хангах дүрэм журам боловсруулахыг эрмэлзэнэ.
- 24.4 Төр болон бусад талууд онцгой байдлын арга хэмжээ авах үедээ эдэлбэрийн асуудлыг анхаарч үзнэ. Шилжин суурьшсан иргэдийн газар, загас, ой нөөц болон амьжиргааны аливаа хангамжийн асуудал нь бусдын амьжиргааг эрсдэлд оруулахааргүй байх ёстой. Шилжин суурьшсан иргэдийн зүй ёсны эдэлбэрийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн хамгаална. Эдэлбэрийн эрх болон

зөвшөөрөлгүй ашиглалтын талаарх мэдээллийг нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст хүргэнэ.

- 24.5 Төр болон бусад талууд сэргээн босголтын үе шатанд эдэлбэрийн асуудалд анхаарал хандуулна. Түр хугацаагаар шилжин суурьшсан иргэдэд анх амьдарч байсан газартаа сайн дураараа, аюулгүй, нэр төртэйгээр буцаж очиход нь туслалцаа үзүүлнэ. Эдэлбэрийн эрхийн маргааныг шийдвэрлэх арга хэрэгслээр хангана. Нэгж талбар болон бусад орон зайн нэгжийн зааг, хязгаарыг дахин тогтоох шаардлагатай тохиолдолд энэхүү зөвлөмжийн зөвлөгөөн, оролцооны зарчмыг баримтлан ажиллана. Хүмүүс анх амьдарч байсан газраа буцаж очих боломжгүй тохиолдолд тэднийг өөр газар түр хугацаагаар шилжүүлэн суурьшуулна. Ингэхдээ дүрвэгсэд болон шилжин суурьшсан хүмүүсийг газар, загас, ойн нөөцөөс ашиглах болон амьжиргааны баталгаагаар хангахдаа бусдын эрх, амьжиргааг эрсдэлд оруулалгүйгээр шийдвэрдэх үүднээс хүлээн авч буй нутгийн иргэд болон холбогдох бусад талуудтай зөвшилцөнө.

25. Газар, загас, ойн эдэлбэртэй холбоотой зөрчилдөөн

- 25.1 Бүх талууд газар, загас, ойн эдэлбэрийн асуудал зөрчилдөөний шалтгаан болохоос урьдчилан сэргийлж, зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авах ёстой хийгээд эдэлбэртэй холбоотой асуудлуудыг зөрчилдөөний өмнө, дунд болон дараагийн үе шатанд шийдвэрлэх тухайлбал, булаан эзлэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд холбогдох олон улсын хүмүүнлэгийн хуулийн дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
- 25.2 Бүх үйл ажиллагаа үндэсний хуулийн дагуу явагдаж, үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн төрийн хүчин төгөлдөр үүрэг, бүсийн болон олон улсын холбогдох бичиг баримтаар сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь тухайлбал Дүрвэгсдийн Байдал ба Холбогдох Протоколтой хамааралтай конвенцүүд, Дүрвэгсэд ба шилжин суурьшсан хүмүүсийн орон сууц, эд хөрөнгийн эрхийг сэргээх тухай НҮБ-ын зарчим ("Пинхерогийн Зарчим") зэрэгт нийцсэн байна. Зөрчилдөөний үеэр болон дараа нь төрөөс зүй ёсны эдэлбэрийн эрхтэй холбоотой олон улсын хүмүүнлэгийн холбогдох хуулийг хүндэтгэн үзнэ.
- 25.3 Эдэлбэрийн асуудлуудыг зөрчилдөөнд хүргэхгүйн тулд бүх талууд тухайн асуудлуудыг тайван замаар шийдвэрлэх арга хэмжээг авна. Төрөөс зөрчилдөөнд хүргэж болзошгүй алагчлах болон бусад хүчин зүйлүүдийг арилгах зорилгоор холбогдох бодлого, хуулиудыг дахин хянан хэлэлцэнэ. Зохистой тохиолдолд, төр газар, загас, ойн эдэлбэрийн эрхтэй холбоотой маргааныг шударга, найдвартай, жендерийн мэдрэмжтэй, хүртээмжтэй, алагчлалгүй хэлбэрээр шуурхай шийдвэрлэдэг уламжлалт ёсны болон орон

нутгийн бусад механизмуудыг ашиглаж болно.

- 25.4 Зөрчилдөөн гарсан тохиолдолд, төр болон бусад талууд хүчин төгөлдөр зүй ёсны эдэлбэрийн эрхийг хүндэтгэн хамгаалж, тэдгээрийг бусад талууд зөрчихгүй байх баталгаагаар хангахыг эрмэлзэнэ. Төр үндэсний болон олон улсын холбогдох хуулиар хүлээсэн хүчин төгөлдөр үүргийнхээ хүрээнд өөрийн нутаг дэвсгэр дээр хүчээр болон/эсхүл хүчирхийллийн аргаар олж авсан газар, загас, ойн эдэлбэрийн эрхийг хүлээн зөвшөөрөх ёсгүй. Дүрвэгсэд, шилжин суурьшсан хүмүүс болон зөрчилдөөнд өртсөн бусад талуудыг аюулгүй нөхцлөөр, хүлээн авч буй орон нутгийн иргэдийн эдэлбэрийн эрхийг хамгаалсан байдлаар суурьшуулна. Эдэлбэрийн эрхийн зөрчлүүдийг баримтжуулж, шаардлагатай тохиолдолд гарсан даруйд нь шийдвэрлэнэ. Гарсан зөрчлийн үр дагаврыг тодорхойлоход шаардлагатай баталгаа бүрдүүлэх үүднээс болон зөрчлийг арилгах зохих арга хэмжээ авахын тулд эдэлбэрийн эрхийн албан ёсны бүртгэлийг устгах, хулгайд алдагдахаас хамгаалах бөгөөд ийм бүртгэл байхгүй тохиолдолд, хүчин төгөлдөр эдэлбэрийн эрхийг аль болох жендерийн мэдрэмжтэй хэлбэрээр, аман яриа болон гэрчийн мэдүүлэг дээр үндэслэн баримтжуулах шаардлагатай. Дүрвэгсэд болон шилжин суурьшсан хүмүүсийн эдэлбэрийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн хамгаална. Эдэлбэрийн эрх болон зөвшөөрөлгүй ашиглалтын талаарх мэдээллийг нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст хүргэнэ.
- 25.5 Зөрчилдөөний нөхцөлд боломжтой тохиолдолд болон зөрчилдөөн зогссоны дараа, төр болон бусад талууд эдэлбэрийн эрхтэй холбоотой асуудлуудыг жендерийн эрх тэгш байдлыг харгалзан шийдвэрлэхэд анхаарч, нөлөөлөлд өртсөн хүмүүсийн хувьд ирээдүйтэй шийдлүүдийг гаргахад дэмжлэг үзүүлнэ. Эрх сэргээх боломжтой, НҮБ-ын Хүний эрхийн хороо болон бусад холбогдох агентлагуудын тусламжтайгаар эрх сэргээгдэх боломжтой тохиолдолд, дүрвэгсэд болон шилжин суурьшсан хүмүүст анх амьдарч байсан газартаа сайн дураараа, аюулгүй, нэр төртэйгээр буцаж очиход нь холбогдох олон улсын стандартуудын дагуу туслалцаа үзүүлнэ. Эрх сэргээх, нөхөн сэргээх, хохирол барагдуулах үйл ажиллагааг алагчлалгүй, жендерийн мэдрэмжтэй явуулан нийтэд мэдээлж, эрх сэргээх нэхэмжлэлийг түргэн, шуурхай шийдвэрлэнэ. Уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад нутгийн иргэдийн эдэлбэрийн эрхийг сэргээх журамд мэдээллийн уламжлалт эх үүсвэрүүдийг ашиглахыг тусгасан байвал зохино.
- 25.6 Эрх сэргээх боломжгүй тохиолдолд, дүрвэгсэд болон шилжин суурьшсан хүмүүсийг газар, загас, ойн нөөцөөс ашиглах болон амьжиргааны баталгаагаар хангахдаа бусдын эрх, амьжиргааг

эрсдэлд оруулалгүйгээр шийдвэрдэх үүднээс хүлээн авч буй нутгийн иргэд болон холбогдох бусад талуудтай зөвшилцөнө. Боломжтой тохиолдолд, бэлэвсэн эхнэрүүд, өнчин хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийн иргэдэд газар, загас, ойн нөөцөөс олгох баталгаагаар хангах тусгай журам гаргах шаардлагатай.

- 25.7 Зохистой тохиолдолд, зөрчилдөөн үүсэхээс өмнө байсан алагчлал, мөн зөрчилдөөний үеэр үүссэн алагчлалтай холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ бодлого, хуулиудыг дахин нягтлан харах нь зүйтэй. Зохистой болон шаардлагатай тохиолдолд, эдэлбэрийн хариуцлагатай засаглалд зайлшгүй шаардлагатай үйлчилгээ үзүүлэх холбогдох агентлагуудыг дахин үүсгэн байгуулах хэрэгтэй.

Сурталчилгаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

23. Уур амьсгалын өөрчлөлт

- 26.1. Энэхүү зөвлөмжийн сайн дурын мөн чанарын дагуу хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээг төрөөс хариуцна.
- 26.2. Төрөөс энэхүү зөвлөмжийг хамтран хэрэгжүүлэх; өөрсдийн харьяа нутаг дахь хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; газар, загас, ойн эдэлбэрийн засаглалыг сайжруулахад үзүүлэх нөлөөллийг үнэлэх болон үндэсний хүнсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах хүрээнд хүнсний аюулгүй байдлыг хангах, зохистой хүнсээр хангагдах эрхийг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор олон талт оролцогч талуудын хөтөлбөр төлөвлөгөөг орон нутаг, үндэсний болон бүсийн түвшинд бий болгох эсхүл хүчин төгөлдөр үйлчилж буй хөтөлбөрүүдийг ашиглаж болно. Энэхүү үйл явц нь нийгмийн бүх бүлгийг хамарсан, оролцоотой, жендерийн мэдрэмжтэй, хэрэгжих боломжтой, зардал хэмнэсэн, тогтвортой байдлыг хангасан байвал зохилтой. Төр эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхдээ бүсийн болон олон улсын мэргэжлийн байгууллагуудад хандан дэмжлэг авч болно.
- 26.3. Хөгжлийн түншүүд, НҮБ-ын мэрэгшсэн агентлагууд болон бүсийн байгууллагууд энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа гэх мэт улс орнуудын гаргаж буй сайн дурын санаачлагыг хөхүүлэн дэмжинэ. Энэхүү дэмжлэгт техникийн хамтын ажиллагаа, санхүүгийн туслалцаа, байгууллагуудын чадавхи сайжруулах, мэдлэг хуваалцах болон туршлага солилцоо, үндэсний эдэлбэрийн бодлого боловсруулах ба технологи дамжуулахад туслалцаа үзүүлэх зэргийг хамруулна.
- 26.4. Дэлхийн хүнсний аюулгүй байдлын хороо нь холбогдох бүх талууд харилцан туршлагаасаа суралцаж, энэхүү Зөвлөмжийн хэрэгжилтийн явц, зөвлөмжийн ач холбогдол, үр ашиг болон үр нөлөөг үнэлж дүгнэх дэлхийн чуулган болох учиртай. Тиймээс Дэлхийн хүнсний аюулгүй байдлын хорооны нарийн бичгийн дарга нарын газар Зөвлөх хэсэгтэй хамтран энэхүү зөвлөмжийн

хэрэгжилтийн явцыг Дэлхийн хүнсний аюулгүй байдлын хороонд тайлагнах үүрэгтэй бөгөөд, эдэлбэрийн засаглалыг сайжруулахад үзүүлж буй нөлөө, оруулж буй хувь нэмрийг нь үнэлж дүгнэнэ. Тайлан нь дэлхий нийтийн шинжтэй байх хийгээд бүс нутгийн туршлага, шилдэг үйл ажиллагаа, сургамж зэргийг тусгасан байна.

- 26.5. Иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэн зэрэг бүх талууд энэхүү зөвлөмжийг үндэсний тэргүүлэх асуудлууд болон нөхцөл байдлын хүрээнд сурталчлан хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах хэрэгтэй. Бүх талууд бодит үйл ажиллагааг сайжруулахын тулд хариуцлагатай эдэлбэрийн засаглалын талаарх мэдээллийг түгээх нь зүйтэй.



Энэхүү зөвлөмж нь байгалийн нөөцийн эдэлбэр, түүний удирдлагын тухай дэлхий нийтэд зориулан гаргасан засгийн газар хоорондын тохиролцооны зарчмаар хийгдсэн анхны бүрэн хэмжээний бичиг баримт юм.

Зөвлөмж нь газар, загас, ойн нөөцийн ашиглалт, хяналтын хариуцлагатай үйл ажиллагааны зарчмууд, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг тодорхойлж байгаа юм. Зөвлөмж нь байгалийн нөөцийн эдэлбэрийн эрхийн харилцааг зохицуулах бодлого, эрх зүй, бүтэц-зохион байгуулалтыг сайжруулах; эдэлбэрийн системийн ил тод байдал, удирдлагыг сайжруулах; эдэлбэр, эдэлбэрийн засаглалын асуудла эрхэлсэн төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, иргэний нийгмийн байгууллагууд болон ажилтнуудын чадавхи, үйл ажиллагааг сайжруулахад удирдамж болно.

Зөвлөмж нь эдэлбэрийн засаглалыг үндэсний хүнсний аюулгүй байдлын хүрээнд тавьж, зохистой хүнсээр хангагдах эрхийн тууштай хэрэгжилтийг хангах, өлсгөлөнг арилгах, байгаль орчныг хамгаалах болон нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад түлхэц болох зорилготой.

www.fao.org/nr/tenure